2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон жилийн
СТОУС-ын дагуу илэрхийлэгдсэн

# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**СҮҮ**

Хувьцаат Компани

**Ерөнхий мэдээлэл**
**2022 оны 12 -р сарын 31**

| | | |
|---|---|---|
| **Компанийн нэр** | Сүү Хувьцаат Компани | |
| **Регистрийн дугаар** | 2077108 | |
| **Үйл ажиллагааны чиглэл** | Компанийн үндсэн үйл ажиллагаа нь сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа сүүний тээврийн үйлчилгээ болон сүүний үхрийн фермерийн аж ахуй, малын тэжээлийн ургамал, хүнсний ногоо тариалах, бусад хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа болно. | |
| **Гүйцэтгэх удирдлага** | М.Болод | Гүйцэтгэх захирал |
| **Төлөөлөн удирдах зөвлөл** | Д. Ганбаатар | ТУЗ-ийн дарга |
| | Д. Цэрэнжигмэд | ТУЗ-ийн гишүүн |
| | Д. Жамъян | ТУЗ-ийн гишүүн |
| | Ц. Соёл - Эрдэнэ | ТУЗ-ийн гишүүн |
| | Б. Түвшинтөгс | ТУЗ-ийн гишүүн |
| | Д. Уянгалянхуа | ТУЗ-ийн гишүүн |
| | Д. Тунгалаг | ТУЗ-ийн гишүүн |
| | С. Сүхболд | ТУЗ-ийн гишүүн |
| | Г. Баяр | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | Ш. Даваалимбэ | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | П. Мэндсайхан | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | Н. Цэрэндорж | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| **Байнгын хаяг** | **Сүү ХК**<br>Өөрийн байр,<br>Үйлдвэрчний эвлэлийн гудамж, Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо,<br>Улаанбаатар хот, Монгол Улс | |
| **Аудитор** | **БДО Аудит ХХК**<br>Юнион Бюлдинг В блок, 15-р давхар, 1502 тоот,<br>Парисын гудамж, Нарны зам-62, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,<br>Улаанбаатар хот, Монгол Улс | |

**2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 3-7 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь Сүү Хувьцаат Компанийн (Компани) 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

Компани-ийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) -ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

| | | |
|---|---|---|
| **ДАГВАДОРЖИЙН ГАНБААТАР** | **МЭДРААГИЙН БОЛОД** | **ДАВААЛИМБЭ ШИНЭБАЯР** |
| ТУЗ -ын дарга | Гүйцэтгэх захирал | Санхүү албаны дарга |

Огноо: 2023/04/18

Улаанбаатар хот, Монгол улс

Tel: +976 77404040
Fax: +976 77404041
www.bdo.mn
Zip code: 13110

Room 1502, Level 15
Union Building - B, Paris Street
Narnii Zam - 62, Khoroo - 1
Sukhbaatar District, Ulaanbaatar
Mongolia

Утас: +976 77404040
Факс: +976 77404041
www.bdo.mn
ШНК: 13110

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1-р хороо, Нарны зам - 62, Парисын
гудамж, ЮНИОН БЮЛДИНГ Б блок
15 - р давхар, 1502 тоот

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Сүү ХК -ийн Хувьцаа эзэмшигчдэд

## Санал дүгнэлт

Сүү ХК (Компани)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) -ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

## Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (НБЁЗОУСЗ)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм (*Хараат бус Байдлын Олон Улсын Стандартыг багтаасан)* болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус байсан бөгөөд НБЁЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

## Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад томоохон нөлөө үзүүлэх асуудлууд байна. Эдгээр асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор энэхүү гол асуудалд тусад нь дүгнэлт илэрхийлээгүй.

### 1 Биологийн хөрөнгийн анхны болон дараа үеийн хэмжилт

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу компанийн биологийн хөрөнгийг анх болон тайлант жил бүрийн эцэст борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжиж тайлагнахыг шаарддаг.

Аудиторын гүйцэтгэсэн горим:

- Тайлант жил бүрийн эцсээрх биологийн хөрөнгийн биет байдал, хөрөнгийн одоогийн болон цаашдын ашиглалт ба хэрэглээг тодорхойлсон;

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of

BDO

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

## Аудитын гол асуудал (үргэлжлэл)

### 1 Биологийн хөрөнгийн анхны болон дараа үеийн хэмжилт (үргэлжлэл)

Энэхүү бодит үнэ цэний тооцоолол нь удирдлагыг томоохон тооцоолол ба таамаглал хийхийг шаарддаг. Бодит үнэ цэний хэмжилт санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгө болон ашиг, алдагдалд шууд нөлөөлнө.

2022 оны 12-р сарын 31-ний байдлаарх эргэлтийн болон эргэлтийн бус биологийн хөрөнгийн дүн 2,402,698 мянган төгрөг (2021: 0) байна.
Хавсаргасан санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 24-ээс үзнэ үү.

Аудиторын гүйцэтгэсэн горим (үргэлжлэл):

- Удирдлагын гүйцэтгэсэн бодит үнэ цэний тооцоололд ашигласан аргын сонголтын тохиромжтой байдал, ашигласан орц мэдээллийн ул үндэслэлтэй байдлыг үнэлсэн;
- Ижил төстэй биологийн хөрөнгийн зах зээл болон жишиг үнийн судалгаа хийж гүйцэтгэсэн;
- Өмнөх жилд охин компани болох Макс - Агро ХХК -ийн өмнөх жилүүдийн түүхэн мэдээлэлд үндэслэн биологийн хөрөнгийн насжилт, төл өгөх магадлал, сүүний дундаж гарц, бий болгох цэвэр мөнгөн урсгалд таамаглал дэвшүүлж, ирээдүйн ашиглалтаас бий болох таамагласан мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр бодит үнэ цэнийг давтан тооцоолсон.
- Санхүүгийн тайлан дахь холбогдох тодруулгыг зохистой байдлыг үнэлсэн.

### 2 Бараа материалын хэмжилт

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу компанийн бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнэ цэний аль багаар бүртгэхийг шаарддаг.

Энэхүү цэвэр боломжит үнэ цэний тооцоолол нь удирдлагыг бараа материалыг иж бүрдэл болох тооцоолсон зардал болон борлуулахад бэлэн болгох тооцоолсон зардал дээр үндэслэн барааны цэвэр боломжит үнэ цэнийг тооцож, барааны өртөгтэй харьцуулан аль багаар хэмжиж толилуулахыг шаарддаг.

2022 оны 12-р сарын 31-ний байдлаарх бараа материалын дансны үлдэгдэл 21,641,490 мянган төгрөг (2021: 12,839,256 мян.төг) байна.
Хавсаргасан санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 16-аас үзнэ үү.

Аудиторын гүйцэтгэсэн горим:

Тайлант жилийн эцсээр бараа материалын үлдэгдлийн үнэлгээний ул үндэслэлтэй байдлыг шалгахын тулд:

- Эцсийн борлуулах үнэ нь бараа материалын өртөг дээр дуусгавар болгохтой холбогдон гарах нэмэлт зардлын нөөц болон борлуулах зардлыг нэмснээр өндөр гэдгийг баталгаажуулсан.
- Хэвийн арилжааны болон тоо хэмжээний хөнгөлөлтийг харгалзан үзэж борлуулалтын үнийг таамаглан тооцоолсон.
- Дуусгавар болгох хүртэл гарах зардлын тооцооллын ул үндэслэлтэй байдлыг шалгасан.
- Борлуулах зардлын тооцооллыг нягтлан шалгасан.
- Санхүүгийн тайлан дахь холбогдох тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.

BDO

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

## Асуудлыг онцлох нь

Санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 26, Охин компанийг нэгтгэх үйл явдал -д анхаарлаа хандуулна уу. Тэмдэглэл 26 -д дурдсан үйл явдал нь компанийн 2022 оны 04 дүгэр сарын 29 -ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолоор компанийн 100 хувь эзэмшлийн охин компани болох Макс-Агро ХХК - г Сүү ХК -тай нэгтгэх замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэр гарсан. Тус тогтоолын дагуу Макс-Агро ХХК -ийн санхүүгийн тайланг 2022 оны 06 сарын 30 -ны өдрөөр тасалбар болгож компанийн санхүүгийн тайлангийн хуримтлагдсан үр дүнд нэгтгэн харуулсан. Эдгээр асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын ажлын хүрээнд СТОУС -ын болон хууль хэрэгжилтийн дагуу авч үзсэн ба аудитор энэхүү асуудыг онцлох зүйлд тусад нь дүгнэлт илэрхийлээгүй.

## Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь гүйцэтгэх удирдлагын зүгээс хөрөнгө оруулагчид болон нээлттэй зах зээлд зориулан бэлтгэсэн жилийн тайлан, мөн зээлдүүлэгчдэд зориулан бэлтгэсэн бусад тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд бидний аудиторын тайлан ордоггүй.

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцлийг авч үзэхэд оршдог. Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

## Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

## Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангүй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоонд компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the

BDO

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

## Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид эдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл хариу арга хэмжээ зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлыг мэдээлэх нь тухайн мэдээллээс олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

БДО АУДИТ ХХК
AUDIT & ASSURANCE
VALUATION SERVICES
BDO
УЛААНБААТАР ХОТ
ТТН326 № 2546442

Л. БАЯРЦОГЗОЛ

Огноо: 2023 .04. 18

БДО Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Парисын гудамж, Нарны зам-62
Юнион Бюлдинг В блок, 1502 тоот өрөө

## СҮҮ ХК

### 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

| | Тэм | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|---|
| Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого | 5 | 108,774,221 | 100,397,004 |
| Борлуулалтын өртөг | 6 | (78,902,371) | (72,825,355) |
| Үнэ цэний бууралтын нөхөлтийн олз /(гарз) | 17/18 | 809,277 | (304,304) |
| **Нийт ашиг** | | **30,681,127** | **27,267,345** |
| Бусад орлого | 7 | 1,231,651 | 2,422,343 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 8 | (5,903,057) | (4,642,346) |
| Борлуулалт ба маркетингийн зардал | 9 | (9,393,519) | (7,679,906) |
| Биологийн хөрөнгийн бодит үнэ цэний бууралтын гарз | 24 | (267,778) | - |
| Бусад зардал | 11 | (303,998) | (133,704) |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг** | | **16,044,426** | **17,233,732** |
| Санхүүгийн орлого | 12 | 161,495 | 559,322 |
| Санхүүгийн зардал | 12 | (6,363,393) | (4,295,589) |
| **Татварын өмнөх ашиг** | | **9,842,528** | **13,497,465** |
| Орлогын албан татварын зардал | 13 | (1,506,549) | (2,683,053) |
| **Тайлант жилийн ашиг** | | **8,335,979** | **10,814,412** |
| **Нэгж хувьцаанд ногдох ашиг** | | | |
| Суурь болон хорогдуулсан нэгж хувьцаанд ногдох ашиг - төгрөг | 14 | **24.29** | **34.41** |

## СҮҮ ХК

### 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Санхүүгийн байдлын тайлан

| | Тэм | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | | |
| Бараа материал | 16 | 21,641,490 | 12,839,256 |
| Биологийн хөрөнгө | 24 | 638,960 | - |
| Худалдааны болон бусад авлага | 17 | 3,762,032 | 2,138,536 |
| Холбоотой талуудад олгосон зээл | 18 | 571,495 | 5,862,888 |
| Урьдчилж төлсөн төлбөр | 19 | 2,279,634 | 12,250,144 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 20 | 2,242,953 | 7,017,492 |
| | | **31,136,564** | **40,108,316** |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө | 21 | 65,440 | - |
| **Нийт эргэлтийн хөрөнгө** | | **31,202,004** | **40,108,316** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | | |
| Өмч, барилга, тоног төхөөрөмж | 22 | 52,633,934 | 30,649,699 |
| Хөрөнгө ашиглах эрх | 23 | 642,710 | 978,197 |
| Биологийн хөрөнгө | 24 | 1,763,738 | - |
| Биет бус хөрөнгө | 25 | 69,118 | 70,036 |
| Урьдчилж төлсөн төлбөр | 19 | 1,516,620 | 1,700,282 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 26 | - | 16,486,540 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 13 | - | 102,399 |
| **Нийт эргэлтийн бус хөрөнгө** | | **56,626,120** | **49,987,153** |
| **Нийт хөрөнгө** | | **87,828,124** | **90,095,469** |

*Хүснэгтийн үргэлжлэлийг дараагийн хуудаснаас үзнэ үү.*

## СҮҮ ХК

### 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Санхүүгийн байдлын тайлан (*үргэлжлэл*)

| | Тэм | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|---|
| **Өр төлбөр** | | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | | |
| Худалдааны болон бусад өглөг | 27 | 6,493,839 | 2,327,659 |
| Зээл болон өр төлбөр | 28 | 22,835,307 | 17,973,928 |
| Түрээсийн өр төлбөр | 23 | 293,681 | 603,948 |
| Гэрээний өр төлбөр | 5 | 412,911 | 568,050 |
| Орлогын татварын өглөг | 13 | 1,234,692 | 898,603 |
| **Нийт богино хугацаат өр төлбөр** | | **31,270,430** | **22,372,188** |
| **Урт хугацаат өр төлбөр** | | | |
| Зээл болон өр төлбөр | 28 | 18,838,823 | 26,171,763 |
| Түрээсийн өр төлбөр | 23 | 133,947 | 441,306 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 13 | 122,659 | - |
| **Нийт урт хугацаат өр төлбөр** | | **19,095,429** | **26,613,069** |
| **Нийт өр төлбөр** | | **50,365,859** | **48,985,257** |
| **Өмч** | | | |
| Хувьцаат капитал | 29 | 34,400 | 34,400 |
| Нэмж төлөгдсөн капитал | 29 | 60,102 | 49,578 |
| Халаасны хувьцаа | 29 | (89) | (124) |
| Хуримтлагдсан ашиг | | 37,367,852 | 41,026,358 |
| **Нийт өмч** | | **37,462,265** | **41,110,212** |
| **Нийт өр төлбөр ба өмч** | | **87,828,124** | **90,095,469** |

## СҮҮ ХК

### 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тсалбар болсон жилийн Өмчийн өөрчлөлтийн тайлан

| | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Халаасны хувьцаа | Хуримтлагдсан ашиг | Нийт өмч |
|---|---|---|---|---|---|
| | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг |
| **2022 оны 01 сарын 01-ний үлдэгдэл** | **34,400** | **49,578** | **(124)** | **41,026,358** | **41,110,212** |
| Тайлант жилийн ашиг | - | - | - | 8,335,979 | **8,335,979** |
| Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй ашиг | - | - | - | - | **-** |
| **Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг** | **-** | **-** | **-** | **8,335,979** | **8,335,979** |
| Гаргасан хувьцаат капитал | - | 10,557 | 2 | - | **10,559** |
| Төлсөн ногдол ашиг | - | - | - | (3,161,626) | **(3,161,626)** |
| Охин компанийг нэгтгэх үйл явдлаар өмчид орсон өөрчлөлт (Тэмдэглэл26) | - | - | - | (8,832,859) | **(8,832,859)** |
| Өмчийн данс хооронд ангилал | - | (33) | 33 | - | **-** |
| **2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **34,400** | **60,102** | **(89)** | **37,367,852** | **37,462,265** |

*Хүснэгтийн үргэлжлэлийг дараагийн хуудаснаас үзнэ үү.*

*16-87 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

## СҮҮ ХК

### 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
### Өмчийн өөрчлөлтийн тайлан (*үргэлжлэл*)

| | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Халаасны хувьцаа | Хуримтлагдсан ашиг | Нийт өмч |
|---|---|---|---|---|---|
| | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг |
| **2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл** | **34,400** | **-** | **(113)** | **34,556,093** | **34,590,380** |
| Тайлант жилийн ашиг | - | - | - | 10,814,412 | **10,814,412** |
| Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй ашиг | - | - | - | - | **-** |
| **Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг** | **-** | **-** | **-** | **10,814,412** | **10,814,412** |
| Гаргасан хувьцаат капитал | - | 49,578 | 18 | - | **49,596** |
| Төлсөн ногдол ашиг | - | - | - | (4,275,675) | **(4,275,675)** |
| Худалдаж авсан халаасны хувьцаа | - | - | (29) | (68,472) | **(68,501)** |
| **2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **34,400** | **49,578** | **(124)** | **41,026,358** | **41,110,212** |

*16-87 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

## СҮҮ ХК

### 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Мөнгөн гүйлгээний тайлан

| | Тэм | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| **Татварын өмнөх ашиг** | | **9,842,528** | **13,497,465** |
| *Тохируулга:* | | | |
| Өмч, барилга, тоног төхөөрөмжийн элэгдэл | 22 | 3,228,012 | 3,347,367 |
| Хөрөнгө ашиглах эрхийн хорогдуулга | 23 | 573,023 | 1,135,966 |
| Биет бус хөрөнгийн хорогдуулга | 25 | 9,568 | 8,725 |
| Өмч, барилга, тоног төхөөрөмж борлуулсны олз | 22/7 | (22,049) | (3,918) |
| Өмч, барилга, тоног төхөөрөмж данснаас гарз | 22/8 | 639 | 108,013 |
| Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз/(олз) | 12 | 446,360 | (188,434) |
| Авлагын үнэ цэний бууралтын гарз/(олз) | 17/18 | (809,277) | 304,304 |
| Акталсан бараа материал | 16/8 | - | 1,533 |
| Санхүүгийн орлого | 12 | (161,495) | (370,888) |
| Санхүүгийн зардал | 12 | 5,022,654 | 4,144,378 |
| Биологийн хөрөнгийн бодит үнэ цэний гарз | 24/21 | 182,212 | - |
| Биологийн хөрөнгийн хорогдол | | 176,418 | - |
| **Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны ашиг** | | **18,488,593** | **21,984,511** |
| Бараа материалын өсөлт | | (8,147,347) | (896,403) |
| Худалдааны болон бусад авлагын өсөлт | | (1,264,542) | (357,134) |
| Урьдчилж төлсөн төлбөрийн (өсөлт)/бууралт | | 3,652,286 | (6,484,738) |
| Хязгаарласан мөнгөний бууралт | | - | 100,334 |
| Худалдааны болон бусад өглөгийн өсөлт/(бууралт) | | (1,011,432) | 130,808 |
| Гэрээний өр төлбөрийн өсөлт/(бууралт) | | (155,138) | 522,309 |
| **Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгө** | | **11,562,420** | **14,999,687** |
| Төлсөн орлогын албан татвар | 13 | (945,402) | (2,401,042) |
| Хүлээн авсан хүү | 12 | 161,495 | 179,212 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **10,778,513** | **12,777,857** |

*Хүснэгтийн үргэлжлэлийг дараагийн хуудаснаас үзнэ үү.*

## 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Мөнгөн гүйлгээний тайлан (*үргэлжлэл*)

| | Тэм | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|---|
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Худалдан авсан өмч, барилга, тоног төхөөрөмж | 22/33 | (8,491,230) | (9,333,849) |
| Борлуулсан өмч, барилга, тоног төхөөрөмжөөс хүлээн авсан мөнгө | 22 | 251,762 | 47,635 |
| Худалдан авсан биет бус хөрөнгө | 25 | (5,674) | (10,596) |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө борлуулалтаас хүлээн авсан мөнгө | | 10,482 | - |
| Хөрөнгө ашиглах эрх олж эзэмшихэд төлсөн мөнгө | 23 | (128,354) | - |
| Биологийн хөрөнгө дэх хөрөнгө оруулалт | 24 | (396,301) | - |
| Холбоотой талуудад олгосон зээл | 18 | (7,242,802) | (11,568,895) |
| Холбоотой талуудад олгосон зээлийн эргэн төлөлт | 18 | 12,999,060 | 7,169,782 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(3,003,057)** | **(13,695,923)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Гаргасан хувьцаа | - | 10,558 | 49,596 |
| Халаасалсан хувьцаа | - | - | (68,501) |
| Төлсөн ногдол ашиг | 15 | (3,161,626) | (4,275,675) |
| Авсан зээл болон өр төлбөр | 33 | 29,465,345 | 41,420,863 |
| Зээл болон өр төлбөрийн эргэн төлөлт | 33 | (32,553,812) | (27,191,858) |
| Зээл болон өр төлбөрийн хүүгийн төлбөрийн төлөлт | 33 | (5,743,879) | (4,190,860) |
| Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөрийн төлөлт | 23 | (652,525) | (1,186,876) |
| Түрээсийн өр төлбөрийн хүүгийн төлбөрийн төлөлт | 23/12 | (118,202) | (235,038) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(12,754,141)** | **4,321,651** |
| **Тайлант жилд бий болсон/(зарцуулсан) нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(4,978,685)** | **3,403,585** |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **20** | **7,017,492** | **3,707,438** |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө | 12 | 204,146 | (93,531) |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **20** | **2,242,953** | **7,017,492** |

Мөнгөн гүйлгээний тайланг дэмжих мэдээллийг Тэмдэглэл 33-с үзнэ үү

**СҮҮ ХК**

**2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн**
**Санхүүгийн тайлангийн тэмдэглэл**

---

**Агуулга**


1. Тайлагнагч аж ахуйн нэгж ..................... 16
2. Тайлан бэлтгэсэн үндэслэл ................... 16
3. Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл ........................... 19
4. Санхүүгийн хэрэглүүр – эрсдэлийн удирдлага ............................................ 21
5. Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого..................................... 30
6. Борлуулалтын өртөг .............................. 32
7. Үйл ажиллагааны бусад орлого............ 32
8. Ерөнхий ба удирдлагын зардал ........... 33
9. Борлуулалт ба маркетингийн зардал.... 33
10. Ажилчдын тэтгэмжийн зардал ............. 34
11. Бусад зардал .......................................... 34
12. Санхүүгийн орлого, зардал .................... 35
13. Орлогын албан татвар........................... 36
14. Нэгж хувьцаанд ногдох ашиг ................ 38
15. Ногдол ашиг ............................................ 38
16. Бараа материал ..................................... 39
17. Худалдааны болон бусад авлага ........... 40
18. Холбоотой талуудад олгосон зээлийн авлага ...................................................... 43
19. Урьдчилж төлсөн төлбөр........................ 44
20. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө...... 45
21. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө........................... 45
22. Өмч, барилга, тоног төхөөрөмж........... 47
23. Түрээс...................................................... 49
24. Биологийн хөрөнгө................................ 51
25. Биет бус хөрөнгө.................................... 53
26. Охин компанийг нэгтгэх үйл явдал ....... 54
27. Худалдааны болон бусад өглөг ............. 55
28. Зээл болон өр төлбөр............................ 56
29. Хувьцаат капитал ................................... 65
30. Холбоотой талуудын ажил гүйлгээ........ 66
31. Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага 70
32. Тайлагналын өдрийн дараах үйл явдал 70
33. Мөнгөн гүйлгээний тайланг дэмжих тэмдэглэл................................................ 70
34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд... 72
35. Тайлангийн орчуулга ............................. 87

## 1. Тайлагнагч аж ахуйн нэгж

Сүү ХК (Компани) нь 1958 онд анх Сүүний үйлдвэр нэртэйгээр байгуулагдсан ба 1992 онд өмч хувьчлалд хамрагдан Төрийн өмчит Хувьцаат Компанийн хэлбэрт шилжсэн. 2008 онд бүрэн хувьчлагдаж Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй Хувьцаат Компани болсон. Компани нь 1992 оны 02-р сарын 24-ний өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 2077108 тоот регистр бүхий 9010001096 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээг авсан. Улсын бүртгэлийн гэрчилгээг 2010 оны 12-р сарын 30 -ны өдөр дахин шинэчлэн авсан байна

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа сүүний тээврийн үйлчилгээ болон сүүний үхрийн фермерийн аж ахуй, малын тэжээлийн ургамал, хүнсний ногоо тариалах, бусад хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа болно.

2022 оны 12-р сарын 31-ний байдлаар хүчин төгөлдөр Компанийн дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн болон хувьцаат капитал нь дараах байдалтай байна. Үүнд:

| Хувьцаа эзэмшигчдийн нэр | Эзэмшлийн хувь | 2022 оны 12 сарын 31 | | |
|---|---|---|---|---|
| | | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ (төг) | Нийт (мян.төг) |
| Д.Жамъян | 38.69% | 133,103,000 | 0.1 | 13,310 |
| Д.Ганбаатар | 33.06% | 113,730,000 | 0.1 | 11,373 |
| Д.Уянгалянхуа | 21.00% | 72,240,000 | 0.1 | 7,224 |
| Бусад | 7.25% | 24,927,000 | 0.1 | 2,493 |
| **Нийт дүн** | **100%** | **344,000,000** | | **34,400** |

Компанид хамгийн дээд хянагч толгой компани нь байхгүй бөгөөд өөрөө эцсийн толгой компани болно.

Компани нь 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр 558 ажилтан (2021: 524) -тай байсан.

## 2. Тайлан бэлтгэсэн үндэслэл

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуйг Тэмдэглэл 34, Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуйд толилуулсан. Өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд уг бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай баримталж мөрдсөн болно.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн болон тайлагнагч валют нь Монгол улсын мөнгөн тэмдэгт болох Төгрөг юм. Эдгээр санхүүгийн тайлангууд нь төгрөгөөр илэрхийлэгдэж, мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), болон тайлбарууд (хамтад нь СТОУС гэх)-ын дагуу бэлтгэсэн.

## 2. Тайлан бэлтгэсэн үндэслэл (*үргэлжлэл*)

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг. санхүүгийн тайлан бэлтгэхэд хийгдсэн нөлөө бүхий шийдэл ба тооцоолол болон түүний нөлөөллийн талаар Тэмдэглэл 3, Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл-д нэмж тодруулсан.

*Хэмжилтийн үндэслэл*

Эдгээр санхүүгийн тайлангууд нь доорх зүйлсээс (дэлгэрэнгүй мэдээллийг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогоос харна уу) бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн:

- Биологийн хөрөнгө
- Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт**

*(а) 2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд*

2022 оны 01-р сарын 01-нээс хойш хүчин төгөлдөр мөрдөгдөх дараах нэмэлт өөрчлөлтүүд байна:

- Алдагдалтай гэрээ – Гэрээг биелүүлэх өртөг (НББОУС 37-д орсон нэмэлт өөрчлөлт);
- Өмч, барилга, тоног төхөөрөмж: Зориулагдсан ашиглалтаас өмнөх орлого (НББОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт)
- СТОУС 2018-2020 дахь жилийн сайжруулалт (СТОУС 1, СТОУС 9, СТОУС 16 болон НББОУС 41-д орсон нэмэлт өөрчлөлтүүд); ба
- Үзэл баримтлалын хүрээний лавлагаа (СТОУС 3-д орсон нэмэлт өөрчлөлт).

Хэд хэдэн СТОУС-д орсон эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэх тайлант үеүдэд заавал хүчин төгөлдөр мөрдөх болсон.

*Алдагдалтай гэрээ – Гэрээг биелүүлэх өртөг (НББОУС 37-д орсон нэмэлт өөрчлөлт);*

НББОУС 37-д тодорхойлсноор алдагдалтай гэрээ гэдэг нь гэрээний үүргийг биелүүлэхэд гарах, зайлсхийх боломжгүй зардал Компанийн гэрээгээр амласан үүргийг биелүүлэх өртөг) нь уг гэрээний дагуу авахаар хүлээгдэж буй эдийн засгийн өгөөжөөс хэтрэх гэрээ юм.
НББОУС 37.68А-д орсон нэмэлт өөрчлөлтөд зааснаар уг гэрээтэй шууд хамаарах өртөг дараахаас бүрдэнэ:

- Гэрээг биелүүлэх өсөн нэмэгдэх зардал – шууд хөдөлмөр, материал гэх мэт; болон
- Гэрээг биелүүлэхэд шууд хамаарах бусад зардлын хуваарилалт: гэрээг биелүүлэхэд ашиглагдаж буй өмч, барилга, төхөөрөмжийн элэгдлийн зардлаас хуваарилагдсан дүн гэх мэт.

*Өмч, барилга, тоног төхөөрөмж: Зориулагдсан ашиглалтаас өмнөх орлого (НББОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт)*

НББОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт нь тухайн хөрөнгийг зориулагдсан ашиглалтад бэлтгэх явцад бий болгосон зүйлсийн борлуулалтаас хүлээн авсан орлогоор (жишээ нь, бүтээн босголтын дараа болович арилжааны зорилготой үйлдвэрлэл эхлэхээс өмнө, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг тестлэх шатанд үйлдвэрлэсэн дээж бүтээгдэхүүний борлуулалтаас хүлээн авсан орлого) өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлийн өртгийг бууруулахыг хориглох болсон.

## 2. Тайлан бэлтгэсэн үндэслэл (*үргэлжлэл*)

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** *(үргэлжлэл)*

*(а) 2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд (үргэлжлэл)*

*СТОУС 2018-2020 дахь жилийн сайжруулалт (СТОУС 1, СТОУС 9, СТОУС 16 болон НББОУС 41-д орсон нэмэлт өөрчлөлтүүд)*

- СТОУС 1: Анх удаа мөрдөж буй охин компани
- СТОУС 9: Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлтийн '10 хувь'-ийн сорилд багтах шимтгэл
- СТОУС 16: Түрээсийн урамшуулал
- НББОУС 41: Бодит үнэ цэнийн хэмжилт дэх татвар

*Үзэл баримтлалын хүрээний лавлагаа (СТОУС 3-д орсон нэмэлт өөрчлөлт)*

2020 оны 05-р сард НББОУСЗ-өөс СТОУС 3-д бизнесийн нэгдлийн шаардлагуудыг өөрчлөхгүйгээр Санхүүгийн Тайлагналын Үзэл Баримтлалын Хүрээний лавлагааг шинэчлэн өөрчилсөн.

*(б) Хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд*

Компани хугацаанаас нь өмнө хэрэгжүүлэхээр шийдээгүй буюу ирээдүйн нягтлан бодох бүртгэлийн үеүдэд хэрэгжих НББОУСЗ-өөс батлан гаргасан хэд хэдэн стандартууд болон тайлбарууд байна.

2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх стандартууд нь:

- *Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга (НББОУС 1 болон СТОУС-ын Практикын тайлан 2-т орсон нэмэлт өөрчлөлт);*
- *Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт (НББОУС 8-д орсон нэмэлт өөрчлөлт);*
- *Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал (НББОУС 1-д орсон нэмэлт өөрчлөлт);*
- *Нэг удаагийн ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөрт хамаарах хойшлогдсон татвар (НББОУС 12-т орсон нэмэлт өөрчлөлт); ба*
- СТОУС 17 *Даатгалын гэрээ (2023 оны 01-р сарын 01-нээс мөрдөнө)* – 2020 оны 06-р сард Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс СТОУС 17-г 2023 оны 01-р сарын 01-нээс хүчин төгөлдөр мөрдөх нэмэлт өөрчлөлтийг баталсан.

## 2. Тайлан бэлтгэсэн үндэслэл (*үргэлжлэл*)

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** (*үргэлжлэл*)

2024 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх стандартууд нь:

- *СТОУС 16 Түрээс* (Нэмэлт өөрчлөлт – Борлуулалт ба буцаан түрээсийн өр төлбөр);
- *НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга (Нэмэлт өөрчлөлт – Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал)*
- *НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга (Нэмэлт өөрчлөлт – Гэрээтэй эргэлтийн бус өр төлбөр).*

## 3. Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл

Компани нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Ирээдүйд бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно. Дараагийн санхүүгийн жилүүдэд хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд материаллаг нөлөө үзүүлж болохуйц нөлөө бүхий эрсдэлтэй тооцоолол ба төсөөллийг доор дурдлаа.

***Тооцоолол ба төсөөлөл***

*Бусад*

- Худалдааны болон бусад авлагын үнэ цэнийн бууралт – Хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцоолол (Тэмдэглэл 17-ийг үзнэ үү)
- Холбоотой талуудад олгосон зээлийн үнэ цэнийн бууралт - Хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцоолол (Тэмдэглэл 18-ыг үзнэ үү)
- Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийн тооцоолол (Тэмдэглэл 16-ыг үзнэ үү)
- Тайлант жилийн болон хойшлогдсон татварын тооцоолол – татварын байр суурьтай холбоотой тодорхой бус байдал болон хойшлогдсон татварын хэрэгжих магадлалыг үнэлж үздэг (Тэмдэглэл 13-ыг үзнэ үү)
- Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт – Хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжийн дансны үнийн нөхөгдөх дүнгээс давсан хэсэг (Тэмдэглэл 22, 23, 25-ийг үзнэ үү)
- Элэгдэх хөрөнгийн ашиглалтын хугацаа – Компанийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтад суурилан тайлант үе бүрийн эцэст хөрөнгө ашиглах эрх, биет бус хөрөнгө болон өмч, барилга, тоног төхөөрөмж гэх мэт элэгдэх хөрөнгийн ашиглалтын хугацааг шалгадаг. (Тэмдэглэл 22, 23, 25-ийг үзнэ үү)
- Компани түрээслэгчээр оролцож буй түрээсийн гэрээний хувьд түрээсийн хугацаа тодорхойлох, үүнд, компани түрээслэгчийн сонголтыг хэрэгжүүлэх нь ул үндэслэлтэй эсэхийг тодорхойлох (Тэмдэглэл 23-ыг үзнэ үү)
- Түрээсийн өр төлбөрийн хэмжилтэд ашигласан өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн түвшнийг тодорхойлох (Тэмдэглэл 23-ийг үзнэ үү)

## 3. Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл (*үргэлжлэл*)

***Тооцоолол ба төсөөлөл*** *(үргэлжлэл)*

*Бодит үнэ цэний хэмжилт*

Компанийн санхүүгийн тайлан дахь хэд хэдэн хөрөнгө нь бодит үнэ цэний хэмжилт, тодруулгыг шаарддаг. Эдгээр хөрөнгийн бодит үнэ цэний хэмжилтэд ажиглагдахуйц өгөгдлийг аль болох их хэмжээгээр хэрэглэдэг. Бодит үнэ цэний хэмжилтэд хэрэглэгддэг өгөгдлийг ажиглагдахуйц байдлаар нь гурван түвшинд ангилдаг (бодит үнэ цэний шатлал):

- *Түвшин 1*: Идэвхтэй зах зээл дэх ижил төстэй зүйлсийн жишиг үнэ (тохируулга хийгдээгүй)
- *Түвшин 2*: Түвшин 1-ээс бусад ажиглагдахуйц шууд эсвэл шууд бус өгөгдөл
- *Түвшин 3*: Үл ажиглагдахуйц өгөгдөл (зах зээлийн бус мэдээлэл).

Өгөгдсөн зүйлсийн бодит үнэ цэний хэмжилтэд томоохон нөлөө үзүүлэх хэрэглэсэн өгөгдлийн хамгийн бага түвшинд үндэслэн зүйлсийг дээрх түвшинд ангилдаг. Түвшин хооронд зүйлсийг шилжүүлэхдээ шилжүүлсэн үед нь хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу компанийн биологийн хөрөнгийг анх болон тайлант жил бүрийн эцэст борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмждэг.

Энэхүү бодит үнэ цэний тооцоолол нь удирдлагыг томоохон тооцоолол ба таамаглал хийхийг шаарддаг. Бодит үнэ цэний хэмжилт санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгө болон ашиг, алдагдалд шууд нөлөөлнө.

Компани нь дараах зүйлсийг бодит үнэ цэнээр нь хэмждэг.

- Борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан хөрөнгө (Тэмдэглэл 21)
- Биологийн хөрөнгө (Тэмдэглэл 24)

Дээрх зүйлсийн бодит үнэ цэний хэмжилттэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох тэмдэглэлээс харна уу.

## 4. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

***(ii) Санхүүгийн хэрэглүүрийн ангилал***

**Санхүүгийн хөрөнгө**

| | Бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар илэрхийлэгдэх | | Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх | | Бодит үнэ цэн нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | - | - | 2,242,953 | 7,017,492 | - | - |
| Худалдааны болон бусад авлага | - | - | 1,944,118 | 1,584,451 | - | - |
| Холбоотой талуудаас авах авлага | - | - | 571,495 | 5,862,888 | - | - |
| **Нийт санхүүгийн хөрөнгө** | **-** | **-** | **4,758,566** | **14,464,831** | **-** | **-** |

**Санхүүгийн өр төлбөр**

| | Бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар илэрхийлэгдэх | | Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх | | Бодит үнэ цэн нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
| Худалдааны болон бусад өглөг | - | - | (5,357,465) | (2,037,950) | - | - |
| Зээл болон өр төлбөр | - | - | (41,674,130) | (44,145,691) | - | - |
| **Нийт санхүүгийн өр төлбөр** | **-** | **-** | **(47,031,595)** | **(46,183,641)** | **-** | **-** |

## 4. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (*үргэлжлэл*)

***(iii) Бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хэрэглүүр***

Бодит үнэ цэнээр хэмжигддэггүй санхүүгийн хэрэглүүрт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, худалдааны болон бусад авлага, холбоотой талуудад олгосон зээл, худалдааны болон бусад өглөг болон зээлийн өглөг багтана.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, худалдааны болон бусад авлага, худалдааны ба бусад өглөг нь богино хугацаат шинж чанартай байдаг тул тэдний дансны үнэ цэн нь бодит үнэ цэнтэйгээ ойролцоо байдаг.

***(iv) Бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн хэрэглүүр***

Компани нь тайлант жилүүдэд бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн хэрэглүүр эзэмшээгүй байна.

***Ерөнхий Зорилго, Бодлого ба Процесс***

Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн эрсдэлийн удирдлагын зорилго, бодлогыг тодорхойлж түүнд үндсэн үүрэг хариуцлага хүлээхийн зэрэгцээ компанийн санхүүгийн үйл ажиллагааны зорилго, бодлогыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх процессыг боловсруулж, үйл ажиллагааг нь явуулах эрх мэдэлтэй байдаг. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодтой байна. Аудитын хорооны удирдлагаар Компанийн дотоод аудиторын зүгээс гэнэтийн болон төлөвлөгөөт шалгалтыг үйл ажиллагаа болон санхүүгийн бүртгэл рүү чиглэж, хяналт тавьдаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн үндсэн зорилго бол компанийн өрсөлдөх чадвар, уян хатан байдалд нөлөөлөхгүйгээр эрсдэлийг аль болох бууруулах чиглэсэн бодлого тогтоох явдал юм. Эдгээр бодлогын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дор харууллаа:

*Зээлийн эрсдэл*

Компанийн харилцагч ба хамтрагч тал нь гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйн улмаас санхүүгийн алдагдал хүлээх эрсдэлийг зээлийн эрсдэл гэнэ. Компани нь зээлийн борлуулалтаас үүдэлтэй болон холбоотой талуудад олгосон санхүүжилтийн авлагаас шалтгаалан зээлийн эрсдэлд голчлон өртөж байна. Компани шинэ харилцагчтай гэрээ байгуулахын өмнө түүний зээлийн эрсдэлийг үнэлэх бодлого баримталдаг. Энэхүү зээлийн үнэлгээг бизнесийн үйл ажиллагаандаа ашигладаг.

Борлуулалтын албанаас гаргасан зээлийн бодлогын дагуу шинэ харилцагчдад Компанийн стандарт төлбөрийн болон хүргэлтийн нөхцөлүүдийг санал болгохоос өмнө харилцагчийн зээлийн төлбөрийн чадварын шинжилгээг гүйцэтгэдэг. Зээлийн эрсдэлийг Компанийн тогтоосон бодлого, журам болон зээлийн эрсдэлийн удирдлагатай холбоотой хяналтад тулгуурлан удирддаг. Үүнээс гадна авлагуудыг байнга хянаж байдаг. Тайлант хугацаа бүрд худалдааны авлагууд үнэ цэний бууралтад орсон эсэхийг Компани үнэ цэний бууралтын сангийн матриц ашиглан үздэг. Сангийн матриц нь Компанийн түүхэн мэдээлэл болох хугацаа хэтэрсэн хоногт суурилдаг. Компани түүхэн мэдээлэлд үндэслэсэн сангийн матрицыг ирээдүйд чиглэсэн тооцооллоор тохируулдаг. Тайлагналын өдөр бүр түүхэн чанаргүй болох магадлалын түвшнийг шинэчлэн ирээдүйд чиглэсэн тооцооллыг шинжилдэг.

## 4. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (*үргэлжлэл*)

***Зээлийн эрсдэл** (үргэлжлэл)*

Компани бусад авлага болон холбоотой талуудад олгосон зээлийн авлагын хувьд үнэ цэний хүлээгдэж буй алдагдлыг тооцохдоо үнэ цэний бууралтын ерөнхий аргачлалыг ашиглаж зээлийн эрсдэлийг тооцож гаргадаг. Худалдааны болон бусад авлагын зээлийн эрсдэл болон холбоотой талуудад олгосон зээлийн авлагын эрсдэлийн талаарх дэлгэрэнгүй тодруулгыг Тэмдэглэл 17 ба 18 -аас үзнэ үү.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө болон банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламжаас мөн зээлийн эрсдэл үүснэ.

**Банкны харилцах болон хадгаламжийн данс дахь мөнгө**

Компанийн харилцах болон хадгаламжийн даснууд нь дараах банк, санхүүгийн байгууллагуудад байршиж байна. (Стандарт энд Пүүрс агентлагийн рейтинг дээр үндэслэн нэгтгэн дор харуууллаа):

| | 2022 оны 12 сарын 31 | | | 2021 оны 12 сарын 31 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Зэрэглэл (Стандарт энд Пүүрс) | Банкин дахь харилцах данс мян.төг | Богино хугацаат хадгаламж мян.төг | Зэрэглэл (Стандарт энд Пүүрс) | Банкин дахь харилцах данс мян.төг | Богино хугацаат хадгаламж мян.төг |
| Худалдаа хөгжлийн банк | B3 | 58,608 | - | B3 | 60,163 | - |
| Голомт банк | B3 | 403,005 | - | B3 | 75,704 | - |
| Хаан банк | B3 | 529,572 | - | B3 | 342,080 | - |
| Хас банк | B3 | 1,032,842 | 23,326 | B3 | 6,313,228 | 95,719 |
| Төрийн банк | B3 | 64,927 | - | B3 | 100,563 | - |
| **Тэмдэглэл 20, Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө** | | **2,088,954** | **23,326** | | **6,891,738** | **95,719** |

Тайлагналын өдрөөр удирдлага нь эдгээр санхүүгийн байгууллагууд өөрсдийн үүргээ биелүүлээгүйгээс алдагдал хүлээнэ гэж үзэхгүй байна. Үнэ цэний бууралтын шаардлагад нийцээгүй бүх санхүүгийн хөрөнгийн зээлийн алдагдалд өртөх хамгийн дээд хэмжээ нь дансны үнээр илэрхийлэгдэнэ.

## 4. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (*үргэлжлэл*)

*Зах зээлийн эрсдэл*

Хүүтэй, арилжаалагдах болон гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэглүүр хэрэглэснээс үүдэлтэйгээр компани зах зээлийн эрсдэлд өртдөг. Энэ нь хүүгийн түвшин (хүүгийн түвшний эрсдэл), гадаад валютын ханш (гадаад валютын эрсдэл) эсвэл зах зээлийн бусад хүчин зүйлсэд (бусад үнийн эрсдэл) гарсан өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэн эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм.

*Хүүгийн түвшний эрсдэл*

Хүүгийн түвшний эрсдэл гэдэг нь зах зээл дэх зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэн эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм.

Компани нь тогтмол хүүтэй, урт болон богино хугацаат зээлээс үүдэлтэй мөнгөн урсгалын хүүгийн түвшний эрсдэлд өртдөг. Компани хүү бүхий өр төлбөрийг аль болох бага хэмжээнд байлгах зорилго тавьдаг.

2022 болон 2021 онд компанийн зээлүүд нь Евро болон Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

Компанийн хүүтэй зээл болон өр төлбөрийн үлдэгдэл болон хүүгийн түвшин нь дараах байдалтай байна:

| | Валют | Жилийн хүүгийн түвшин | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|---|---|
| Зээл 1 - ЕСБХБ-Хас банк 154-878 | Төгрөг | 13.75% | 9,860,289 | 16,433,814 |
| Зээл 2 – ЕСБХБ -Хас банк 154-1142 | Төгрөг | 13.35% | 12,869,918 | 13,674,288 |
| Зээл 3 - Хас банк 154-1170 | Төгрөг | 13.2% | 1,765,333 | 2,648,000 |
| Зээл 4 - Хас банк 154-1253 | Төгрөг | 16.8% | 2,857,143 | - |
| Зээл 5 - Хас банк 154-3004 | Төгрөг | 18% | 3,880,000 | - |
| Зээл 6 - Хас банк 3Г5001029952-01 | Төгрөг | 18% | 2,343,149 | 7,165,040 |
| Зээл 7 - Хас банк 3Г5002520490 | Төгрөг | 14.4% | 4,263,036 | - |
| Зээл 8 - Тариалан эрхлэлтийг дэмжих сан зээл УСТ-2019/12 | Доллар | 2% | 476,739 | - |
| Зээл 9 – Серак -аас авсан зээл | Евро | 2.5% | 1,908,196 | 2,514,335 |
| Зээл 10 - Номин Юнион ХЗХ-с авсан зээл | Төгрөг | 17.88% | 177,664 | - |
| Зээл 10 - Номин Юнион ХЗХ-2-с авсан зээл | Төгрөг | 26% | 707,297 | 1,000,000 |
| **Нийт** | | | **41,108,764** | **43,435,477** |

## 4. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (*үргэлжлэл*)

*Гадаад валютын эрсдэл (үргэлжлэл)*

Гадаад валютын эрсдэл гэдэг нь гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэн хэлбэлзэх эрсдэл юм. Ирээдүйн ажил гүйлгээ, хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгө, өр төлбөр Монгол Төгрөгөөс өөр валютаар илэрхийлэгдсэн тохиолдолд гадаад валютын эрсдэл үүсдэг. Компанийн гадаад валютын эрсдэл нь гадаад валютаар илэрхийлэгдсэн зээл болон гадаад валютаар илэрхийлэгдсэн худалдааны өглөгөөс үүсдэг. Компани нь өөрийн валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хамгийн сайн, боломжит ханшийг хэрэглэн удирдах бодлогыг барьдаг. Компани үйл ажиллагааны валютаас бусад валютаар гүйлгээ хийхдээ өртөж болох эрсдэлийн түвшнийг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд барьж байдаг. Доорх хүснэгтэд 12-р сарын 31-ний байдлаарх гадаад валютын цэвэр эрсдэлийг харууллаа:

| | Төгрөг | | Ам доллар | | Бусад[1] | | Нийт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **12 сарын 31** | **2022** | **2021** | **2022** | **2021** | **2022** | **2021** | **2022** | **2021** |
| | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** |
| **Санхүүгийн хөрөнгө** | | | | | | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 865,718 | 6,825,264 | 1,231,685 | 10,637 | 145,550 | 181,591 | 2,242,953 | 7,017,492 |
| Худалдааны болон бусад авлага | 1,944,118 | 1,584,451 | - | - | - | - | 1,944,118 | 1,584,451 |
| Холбоотой талуудад олгосон зээл | 571,495 | 5,862,888 | - | - | - | - | 571,495 | 5,862,888 |
| **Нийт санхүүгийн хөрөнгө** | **3,381,331** | **14,272,603** | **1,231,685** | **10,637** | **145,550** | **181,591** | **4,758,566** | **14,464,831** |
| **Санхүүгийн өр төлбөр** | | | | | | | | |
| Худалдааны болон бусад өглөг | (4,943,250) | (1,671,632) | (289,151) | (70,643) | (125,064) | (295,675) | (5,357,465) | (2,037,950) |
| Зээл болон өр төлбөр[1] | (39,289,195) | (41,631,356) | (476,739) | - | (1,908,196) | (2,514,335) | (41,674,130) | (44,145,691) |
| **Нийт санхүүгийн өр төлбөр** | **(44,232,445)** | **(43,302,988)** | **(765,890)** | **(70,643)** | **(2,033,260)** | **(2,810,010)** | **(47,031,595)** | **(46,183,641)** |
| **Нийт цэвэр өртөмхий байдал** | **(40,851,114)** | **(29,030,385)** | **465,795** | **(60,006)** | **(1,887,710)** | **(2,628,419)** | **(42,273,029)** | **(31,718,810)** |

[1] Бусад валютаар илэрхийлсэн зээлийн өглөг нь Сүү ХК -ийн еврогоор төлөх зээлийн дүнг илэрхийлнэ.

## 4. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (*үргэлжлэл*)

*Гадаад валютын эрсдэл (үргэлжлэл)*

Дараах хүснэгтэд тайлант хугацааны эцсийн өдрөөр (бусад бүх хувьсагч тогтмол байхад) бусад валютыг үйл ажиллагааны валют рүү хөрвүүлэх ханш өөрчлөгдөхөд Компанийн ашиг алдагдал болон өөрийн хөрөнгийн дүнд ямар нөлөө үзүүлэхийг харуулсан болно:

| | **Ашиг, алдагдалд үзүүлэх нөлөө 2022он мян.төг** | **Ашиг, алдагдалд үзүүлэх нөлөө 2021 он мян.төг** |
|---|---|---|
| Ам доллар 20%-иар чангарсан үед (2021: 20%) | 93,159 | (12,001) |
| Ам доллар 20%-иар суларсан үед (2021:20%) | (93,159) | 12,001 |
| Бусад 20%-иар чангарсан үед (2021: 20%) | (377,542) | (525,684) |
| Бусад 20%-иар суларсан үед (2021: 20%) | 377,542 | 525,684 |

*Бусад зах зээлийн үнийн эрсдэл*

Компани зах зээлийн үнийн хэлбэлзлээс ашиг хүртэх зорилгоор аливаа өрийн болон өмчийн хэрэглүүр эзэмшдэггүй учир зах зээлийн үнийн эрсдэлд өртөхгүй гэж үзэж байна.

*Төлбөрийн чадварын эрсдэл*

Төлбөрийн чадварын эрсдэл нь компанийн мөнгөн урсгалыг удирдах чадвараас үүсдэг. Төлбөрийн чадварын эрсдэл нь аливаа компани санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэл үүсэх эрсдэлийг илэрхийлдэг. Компанийн бодлого бол өр төлбөр төлөх хугацаа болоход гэрээгээр хүлээсэн төлбөр төлөх үүргээ биелүүлэхийн тулд хангалттай хэмжээний бэлэн мөнгөний үлдэгдэлтэй (эсвэл харилцан тохиролцсон хэрэглүүр) байх явдал юм. Энэ зорилгодоо хүрэхийн тулд компанийн эдийн засагч сар бүр мөнгөн урсгалын төлөвлөгөө боловсруулж, бодит үр дүнд хяналт тавих замаар мөнгөний хэрэгцээ шаардлагыг тодорхойлж сул чөлөөтэй мөнгийг хугацаатай эсвэл хугацаагүй хадгаламжид байршуулах эсвэл нэмж зээл санхүүжилт авах эсэх төлөвлөгөө гаргаж удирдах зөвлөлд тайлагнадаг.

## 4. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (*үргэлжлэл*)

*Төлбөрийн чадварын эрсдэл (үргэлжлэл)*

Дараах хүснэгтээр санхүүгийн өр төлбөрийн гэрээгээр хүлээсэн төлөгдөж дуусах хугацааг харууллаа (гэрээний дискаунтчилаагүй мөнгөн гүйлгээг илэрхийлнэ):

| **2022 оны 12 сарын 31** | **1 жил хүртэл мян.төг** | **1 ээс 2 жил мян.төг** | **2 жилээс дээш мян.төг** | **Нийт мян.төг** |
|---|---|---|---|---|
| Худалдааны болон бусад өглөг | (5,357,465) | - | - | **(5,357,465)** |
| Зээл болон өр төлбөр | (25,842,984) | (13,849,072) | (7,231,655) | **(46,923,711)** |
| Түрээсийн өр төлбөр | (343,266) | (299,721) | (85,617) | **(728,604)** |
| **Нийт дүн** | **(31,543,715)** | **(14,148,793)** | **(7,317,272)** | **(53,009,780)** |

| **2021 оны 12 сарын 31** | **1 жил хүртэл мян.төг** | **1 ээс 2 жил мян.төг** | **2 жилээс дээш мян.төг** | **Нийт мян.төг** |
|---|---|---|---|---|
| Худалдааны болон бусад өглөг | (2,037,950) | - | - | **(2,037,950)** |
| Зээл болон өр төлбөр | (21,368,040) | (14,176,656) | (16,633,284) | **(52,177,980)** |
| Түрээсийн өр төлбөр | (696,392) | (626,201) | - | **(1,322,593)** |
| **Нийт дүн** | **(24,102,382)** | **(14,802,857)** | **(16,633,284)** | **(55,538,523)** |

## 4. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (*үргэлжлэл*)

*Капиталын тодруулга*

Компани нь өмчийн бүх бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдсэн (хувьцаат капитал, нэмж төлөгдсөн капитал, хуримтлагдсан ашиг гэх мэт) нийт капитал-д хяналт тавьдаг. Капитал бүрдүүлэх үеийн Компанийн зорилго бол:

- Хувьцаа эзэмшигч болон хувь нийлүүлэгчдэд үргэлжлүүлэн өгөөж өгөхийн тулд байгууллагын тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадварыг хамгаалах, болон
- Эрсдэлийн түвшнийг харгалзан үзэж бүтээгдэхүүн, үйлчилгээний үнээ тогтоох замаар хувьцаа эзэмшигчдэд зохих өгөөж өгөх явдал юм.

Компани шаардлагатай капиталын дүнг холбогдох эрсдэлтэй нь уялдуулан тогтоодог. Компани капиталын бүтцийг удирдаж, зохих тохируулгыг хийхдээ эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт болон тухайн хөрөнгийн эрсдэлийн шинж чанарыг авч үздэг. Капиталын бүтцийг тогтворжуулах эсвэл түүнд тохируулга хийхийн тулд Компани ногдол ашиг болон капиталын өгөөжийн дүнд тохируулга хийх, шинэ хувьцаа гаргах эсвэл өр бууруулах зорилгоор хөрөнгө борлуулах арга хэмжээ авах боломжтой.

Компани нь Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны зээлтэй бөгөөд зээлийн гэрээний дагуу Сүү ХК - ийн санхүүгийн тайлангийн цэвэр өр ба өмчийн харьцааг хамгийн багадаа 1.3 : 1.0 байлгах шаардлага тавигддаг. Зээлийн гэрээгээр хүлээсэн капиталын шаардлагыг хангаагүй тохиолдол Компани нь зээлийн үндсэн төлбөр болон хүүг бүхэлд нь буюу хэсэгчлэн нэн даруй буцаан төлөх үүрэг хүлээнэ. 2022 болон 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд үндэслэн тооцоолсон цэвэр өр ба өмчийн харьцааг доор харуууллаа:

| | **2022 оны 12 сарын 31 мян.төг** | **2021 оны 12 сарын 31 мян.төг** |
|---|---|---|
| Зээл ба өр төлбөр | 41,674,131 | 44,145,692 |
| Түрээсийн өр төлбөр | 427,627 | 1,045,254 |
| Хасах нь: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | (2,242,953) | (7,017,492) |
| **Цэвэр өр төлбөр** | **39,858,805** | **38,173,454** |
| **Нийт капитал** | **37,462,265** | **41,110,212** |
| **Өр төлбөр ба капиталын харьцаа (коэффициент)** | **1.06** | **0.93** |

## 5. Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого

*Орлогын задаргаа*

Компани нь Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг бөгөөд орлогоо дараах хүснэгтэд орлогын шинж чанар, дүн, хугацаа зэрэг зүйлсээр задалж харуулсан.

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| ***Зах зээлийн газар зүйн байршлаар:*** | | |
| Монгол улс | 108,774,221 | 100,397,004 |
| **Нийт дүн** | **108,774,221** | **100,397,004** |
| ***Бүтээгдэхүүний төрлөөр:*** | | |
| Сүүний борлуулалт | 58,254,785 | 50,601,480 |
| Тарагны борлуулалт | 21,305,231 | 21,348,969 |
| Асептик савлагаатай бүтээгдэхүүний борлуулалт | 9,166,340 | 11,142,117 |
| Зайрмагны борлуулалт | 6,733,454 | 6,188,384 |
| Аарцны борлуулалт | 3,836,837 | 3,226,526 |
| Зөөхийний борлуулалт | 3,366,493 | 1,740,585 |
| Цөцгийн тосны борлуулалт | 3,022,725 | 2,483,968 |
| Пет савлагаатай бүтээгдэхүүний борлуулалт | 2,171,637 | 2,521,427 |
| Бусад борлуулалт | 916,719 | 1,143,548 |
| **Нийт дүн** | **108,774,221** | **100,397,004** |
| ***Гэрээнд оролцогч талуудаар:*** | | |
| Эцсийн хэрэглэгч | 74,236,761 | 67,758,166 |
| Сүлжээ дэлгүүр | 25,757,895 | 22,243,149 |
| Гэрээт борлуулагч | 6,730,947 | 7,085,804 |
| Холбоотой тал | 2,048,618 | 3,309,885 |
| **Нийт дүн** | **108,774,221** | **100,397,004** |
| ***Бараа, ажил үйлчилгээг шилжүүлэх хугацаагаар:*** | | |
| Тодорхой нэг хугацаанд | 108,774,221 | 100,397,004 |
| Тодорхой хугацааны турш | - | - |
| **Нийт дүн** | **108,774,221** | **100,397,004** |

## 5. Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого (*үргэлжлэл*)

*Гүйцэтгэлийн үүрэг*

Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалт

Компани худалдан авагчтай байгуулсан гэрээний дагуу үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлдэг ба бараа бүтээгдэхүүнийг худалдан авагчийн заасан байршилд хүлээлгэн өгснөөр барааны хяналт шилжсэн гэж үзэж орлого хүлээн зөвшөөрдөг. Гэрээний дагуу гэрээний төрлүүдийн хувьд төлбөр төлөгдөх нөхцөлүүд өөр өөр байдаг ба

- сүлжээ дэлгүүрүүдтэй байгуулсан гэрээний хувьд бараа бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгснөөс хойш 7 хоног,
- түрээсийн гэрээгүй сүлжээ дэлгүүрүүдийн хувьд сар бүрийн 25-аас 30-ны хооронд төлбөрөө шилжүүлдэг, ба
- жижиг дэлгүүрүүдийн хувьд барааг хүлээн авахаасаа өмнө захиалга өгөхдөө төлбөрөө шилжүүлсэн байх нөхцөлүүдтэй байна.

Бараа борлуулалттай холбоотой буцаалт нь худалдан авагч талаас үл хамаарах үйлдвэрийн гологдол, тээвэрлэлт, ачилт, хүргэлтээс учирсан гэмтэл, барааны чанарын доголдол илрэх, худалдагч тал барааг буцаан татах хүсэлт гаргасан, улирлын чанартай бараа борлуулалтын хугацаа дууссан зэрэг нөхцөлүүдэд барааг буцаан таталт хийдэг ба буцаалтыг борлуулалтын үнийн дүнгийн 1,5% -иас хэтрэхгүй байх бодлого баримталдаг. Хэрэв нийт борлуулсан дүнгийн 1,5% -иас буцаалт хэтэрсэн тохиолдолд холбогдох борлуулалтын ажилтан хариуцдаг байна. Энэ нь материаллаг бус учир буцаалтын өр төлбөрийн нөөц үүсгэж бүртгэдэггүй. Бөөний худалдан авагчдад сар бүрийн нийт худалдан авалтын үнийн дүнгээс хамаарсан хөнгөлөлт олгодог бөгөөд сар бүрийн эцэст хөнгөлөлтийн үнийн дүн тодорхой болдог учир хувьсах төлбөртэй холбоотой томоохон тооцоолол таамаглал ашигладаггүй.

*Гэрээний үлдэгдэл*

Худалдан авагчтай байгуулсан гэрээнээс тайлант хугацаанд гэрээний хөрөнгө үүсээгүй харин орлогоор хүлээн зөвшөөрөөгүй урьдчилж орж ирсэн мөнгөн төлбөрөөс гэрээний өр төлбөр үүсдэг.

| | Гэрээний өр төлбөр | |
|---|---|---|
| | **2022 он мян.төг** | **2021 он мян.төг** |
| **1 сарын 1-ний үлдэгдэл** | **568,050** | **45,740** |
| Тайлант хугацаанд гэрээний өр төлбөрөөс хүлээн зөвшөөрсөн орлого | (4,366,109) | (7,897,625) |
| Тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй гүйцэтгэлд урьдчилж авсан мөнгө | 4,597,822 | 8,442,413 |
| Гэрээ цуцлагдаж төлбөрийг буцаан шилжүүлсэн | (386,852) | (22,478) |
| **12 сарын 31-ний үлдэгдэл** | **412,911** | **568,050** |

## 5. Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого (*үргэлжлэл*)

*Практик чөлөөлөлт*

Компани нь амласан бараа, үйлчилгээг худалдан авагчид нийлүүлсэн өдөр ба уг бараа, үйлчилгээний үнийг худалдан авагч төлөх өдрийн хоорондох хугацаа нь нэг жил буюу түүнээс богино байна гэж хүлээж байгаа учир санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсгийн нөлөөллийг практик чөлөөлөлт болгон аливаа тохируулга хийхгүй байх сонголтыг хийсэн.

## 6. Борлуулалтын өртөг

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| ***Бүтээгдэхүүн үйлчилгээний төрлөөр*** | | |
| Сүүний борлуулалтын өртөг | (41,780,339) | (34,360,430) |
| Тарагны борлуулалтын өртөг | (15,571,042) | (16,921,437) |
| Асептик савлагаатай бүтээгдэхүүний борлуулалтын өртөг | (8,300,510) | (9,924,042) |
| Зайрмагны борлуулалтын өртөг | (3,723,976) | (3,779,439) |
| Аарцны борлуулалтын өртөг | (2,455,281) | (2,034,604) |
| Зөөхийний борлуулалтын өртөг | (1,953,936) | (918,785) |
| Пэт савалгаатай бүтээгдэхүүний өртөг | (1,746,491) | (2,560,059) |
| Цөцгийн тосны борлуулалтын өртөг | (1,698,052) | (1,178,225) |
| Бусад барааны борлуулалтын өртөг | (1,672,744) | (1,148,334) |
| **Борлуулалтын өртөг** | **(78,902,371)** | **(72,825,355)** |

## 7. Үйл ажиллагааны бусад орлого

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| Бусад орлого | 359,157 | 2,239,208 |
| Түрээсийн орлого | 850,445 | 179,216 |
| Өмч, барилга, тоног төхөөрөмж борлуулсны олз | 22,049 | 3,918 |
| **Нийт дүн** | **1,231,651** | **2,422,343** |

## 8. Ерөнхий ба удирдлагын зардал

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| Цалингийн зардал | (2,401,352) | (2,091,934) |
| Шагнал, урамшууллын зардал | (173,239) | (196,324) |
| Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал | (367,144) | (350,956) |
| Элэгдлийн зардал | (1,212,197) | (740,713) |
| Албан томилолтын зардал | (135,481) | (26,580) |
| Засвар үйлчилгээний зардал | (110,536) | (177,762) |
| Хангамжийн материалын зардал | (114,150) | (75,343) |
| Ашиглалтын зардал | (103,538) | (83,611) |
| Хөдөлмөр хамгааллын зардал | (63,226) | (29,710) |
| Шатахуун болон тээврийн зардал | (56,831) | (37,883) |
| Түрээсийн зардал (Тэмдэглэл 22) | (48,665) | (8,973) |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | (47,609) | (124,016) |
| Даатгалын зардал | (35,353) | (19,145) |
| Харилцаа холбоо, интернэтийн үйлчилгээний зардал | (33,602) | (20,552) |
| Сургалтын зардал | (11,133) | (27,380) |
| Акталсан үндсэн хөрөнгө | (639) | (108,013) |
| Акталсан бараа материал | - | (1,533) |
| Бусад зардал | (988,362) | (521,918) |
| **Нийт дүн** | **(5,903,057)** | **(4,642,346)** |

## 9. Борлуулалт ба маркетингийн зардал

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| Цалингийн зардал | (4,010,504) | (2,616,471) |
| Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал | (532,522) | (364,376) |
| Зар сурталчилгааны зардал | (2,281,484) | (1,460,118) |
| Түрээсийн зардал (Тэмдэглэл 22) | (896,909) | (997,330) |
| Элэгдлийн зардал | (715,257) | (1,287,719) |
| Шатахууны зардал | (558,789) | (378,606) |
| Засвар үйлчилгээний зардал | (178,796) | (117,225) |
| Даатгалын зардал | (72,572) | (3,131) |
| Хангамжийн материал | (16,777) | (114,486) |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил | - | (27,160) |
| Бусад зардал | (129,909) | (313,284) |
| **Нийт дүн** | **(9,393,519)** | **(7,679,906)** |

## 10. Ажилчдын тэтгэмжийн зардал

Ажилчдын тэтгэмжийн зардалд дараах зүйлс багтана (захирлуудын зардал багтсан):

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| Цалингийн зардал | (6,411,856) | (4,708,405) |
| Шагнал, урамшууллын зардал | (173,239) | (196,324) |
| Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал | (899,666) | (715,332) |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил | - | (27,160) |
| **Нийт дүн** | **(7,484,761)** | **(5,647,221)** |

**Гол удирдах албан тушаалтнуудын цалин**

Гол удирдах албан тушаалтан гэдэг нь Компанийн үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх, хянах эрх мэдэл, үүрэг хариуцлага бүхий этгээдүүд бөгөөд Хуудас 1-д жагсаасан компанийн гүйцэтгэх захирлыг хэлнэ.

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| Цалин хөлс | (209,463) | (199,361) |
| Шагнал урамшуулал | (129,416) | (27,041) |
| Нийгмийн даатгалын шимтгэл | (44,570) | (30,596) |
| **Нийт дүн** | **(383,449)** | **(256,998)** |

## 11. Бусад зардал

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| Торгууль хураамжийн зардал | (154,742) | (13,244) |
| Бусад үйл ажиллагааны бус зардал | (130,256) | (120,460) |
| Хандив тусламж | (19,000) | - |
| **Нийт дүн** | **(303,998)** | **(133,704)** |

## 12. Санхүүгийн орлого, зардал

**Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн:**

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| **Санхүүгийн орлого** | | |
| Банкны хадгаламжийн хүүгийн орлого | 161,495 | 370,888 |
| Гадаад валютын ханшийн зөрүүгийн цэвэр олз | - | 188,434 |
| **Нийт санхүүгийн орлого** | **161,495** | **559,322** |
| **Санхүүгийн зардал** | | |
| Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн өр төлбөрийн нийт хүүгийн зардал | (5,591,827) | (4,028,448) |
| *Хасах нь : Үндсэн хөрөнгөд капиталжуулсан зээлийн өртөг* | 687,375 | 119,108 |
| **Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн зээлийн хүүгийн зардал** | **(4,904,452)** | **(3,909,340)** |
| Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал | (118,202) | (235,038) |
| Банкны шимтгэлийн зардал | (91,211) | (151,211) |
| Гадаад валютын ханшийн зөрүүгийн цэвэр гарз | (1,249,528) | - |
| **Нийт санхүүгийн зардал** | **(6,363,393)** | **(4,295,589)** |
| **Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн цэвэр санхүүгийн зардал** | **(6,201,898)** | **(3,736,267)** |

Дээрх санхүүгийн орлого ба зардалд бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар хэмжигдээгүй дараах санхүүгийн хөрөнгө/(өр төлбөр)-т хамаарах хүүгийн орлого/(зардал) багтсан.

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| Санхүүгийн хөрөнгийн нийт хүүгийн орлого | 161,495 | 370,888 |
| Санхүүгийн өр төлбөрийн нийт хүүгийн зардал | (5,591,827) | (3,909,340) |
| **Санхүүгийн хэрэглүүрийн цэвэр хүүгийн зардал** | **(5,430,332)** | **(3,538,452)** |

## 13. Орлогын албан татвар

Орлогын албан татварын өглөгийн хөдөлгөөнийг дараах хүснэгтээр харууллаа:

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| **1 сарын 1-ний үлдэгдэл** | **(898,603)** | **(704,828)** |
| Тайлант жилд ногдуулсан татвар | (1,281,491) | (2,594,817) |
| Төлсөн татвар | 945,402 | 2,401,042 |
| **12 сарын 31-ний үлдэгдэл** | **(1,234,692)** | **(898,603)** |

2022 онд Компани нь Монгол Улсын Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай хуулийн дагуу тайлант жилийн 6 тэрбум төгрөг (2021: 6 тэрбум) хүртэлх татвар ногдуулах орлогоос 10%-иар, 6 тэрбум төгрөгөөс (2021: 6 тэрбум) дээших татвар ногдуулах орлогын дүнд 25%-иар орлогын албан татвар ногдуулж, төлөх үүрэгтэй.

Бодит татварын зардлын хувь болон тайлант жилийн ашгаас хүчин төгөлдөр татварын хувь хэмжээгээр тооцоолсон зөрүүний тооцоо дараах байдалтай байна.

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| **Тайлант жилийн ашиг** | **8,335,979** | **10,814,412** |
| Орлогын татварын зардал | 1,506,549 | 2,683,053 |
| **Татварын өмнөх ашиг** | **9,842,528** | **13,497,465** |
| Тусгайлсан хувь хэмжээгээр татвар ногдох орлого | (171,309) | (370,888) |
| Татвар ногдохгүй орлого | (76,408) | - |
| Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал | - | 696,598 |
| Татвар ногдох түр зөрүү | (1,651,511) | (530,452) |
| Татвараас хасагдах түр зөрүү | 714,138 | 40,250 |
| **Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого** | **8,657,438** | **13,332,973** |
| Татварын хувь хэмжээ | 10%; 25% | 10%; 25% |
| **Тайлант үеийн татварын зардал:** | **1,281,491** | **2,594,817** |
| Нийтлэг хувь хэмжээтэй татварын зардал | 1,264,360 | 2,562,857 |
| Тусгайлсан хувь хэмжээтэй татварын зардал – 10% | 17,131 | 31,960 |
| **Хойшлогдсон татварын зардал** | **225,058** | **88,236** |
| **Нийт орлогын албан татварын зардал** | **1,506,549** | **2,683,053** |

## 13. Орлогын албан татвар (*үргэлжлэл*)

*Тооцоолол ба таамаглал*

2022 оны 12-р сарын 31-ний байдлаар татварын байр суурьтай холбоотой оршин буй материаллаг тодорхой бус байдал байхгүй байна. Энэ үнэлгээг тооцоолол ба төсөөлөлд үндэслэн гүйцэтгэдэг бөгөөд ирээдүйн үйл явдлын тухай нарийн төвөгтэй шийдлүүдийг хамарсан байж болзошгүй. Эдгээр зүйлстэй холбоотой татварын эцсийн үр дүн нь бүртгэсэн дүнгээс ялгаатай байх тохиолдолд тухайн зөрүү нь уг тодорхойлолтыг гаргасан үеийн орлогын татварын зардалд нөлөөлнө. Компани ирээдүйн 5-н жилийн борлуулалтын орлогыг таамаглаж, тухайн таамагласан борлуулалтын орлогод үндэслэн татварын үр ашигт хувь хэмжээг 18% (2021 он: 18 %) байхаар тооцоолон гаргасан. Үүний дагуу ирээдүйд хойшлогдсон татварын хөрөнгө нь 18% -иар хэрэгжиж татварын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ гэж таамаглан 2022 оны 12-р сарын 31- ний өдрөөр Хойшлогдсон татварын үлдэгдлийг тухайн үр ашигт хувь хэмжээгээр хэмжсэн.

***Ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрсөн:***

| **2022 он** | **Эхний үлдэгдэл мян.төг** | **Цэвэр өөрчлөлт мян.төг** | **Эцсийн үлдэгдэл мян.төг** |
|---|---|---|---|
| **Хойшлогдсон татварын хөрөнгө/(өр төлбөр)** | | | |
| Гадаад валютаар илэрхийлэгдсэн өглөгийн үлдэгдлийн ханшийн зөрүүнээс үүссэн түр зөрүү | 101,885 | 79,459 | **181,344** |
| Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллын түр зөрүү | (51,761) | (290,884) | **(342,645)** |
| Түрээс -ийн нөлөөллөөс үүссэн түр зөрүү | 45,029 | (6,387) | **38,642** |
| Бусад | 7,246 | (7,246) | **-** |
| **Нийт** | **102,399** | **(225,058)** | **(122,659)** |

| **2021 он** | **Эхний үдэгдэл мян.төг** | **Цэвэр өөрчлөлт мян.төг** | **Эцсийн үлдэгдэл мян.төг** |
|---|---|---|---|
| **Хойшлогдсон татварын хөрөнгө/(өр төлбөр)** | | | |
| Гадаад валютаар илэрхийлэгдсэн өглөгийн үлдэгдлийн ханшийн зөрүүнээс үүссэн түр зөрүү | 145,861 | (43,976) | **101,885** |
| Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллын түр зөрүү | (19,640) | (32,121) | **(51,761)** |
| Түрээс -ийн нөлөөллөөс үүссэн түр зөрүү | 64,414 | (19,385) | **45,029** |
| Бусад | - | 7,246 | **7,246** |
| **Нийт** | **190,635** | **(88,236)** | **102,399** |

## 14. Нэгж хувьцаанд ногдох ашиг

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| ***Хүртвэр*** | | |
| Тайлант жилийн татварын өмнөх ашиг | 9,842,528 | 13,497,465 |
| Тайлант жилийн татварын зардал | (1,506,549) | (2,683,053) |
| **Хорогдуулсан нэгж хувьцаанд ногдох ашгийг тогтооход хэрэглэсэн ашиг** | **8,335,979** | **10,814,412** |
| ***Хуваарь*** | | |
| Үндсэн нэгж хувьцаанд ногдох ашгийг тогтооход хэрэглэгдсэн хувьцааны жигнэсэн дундаж тоо хэмжээ | 343,180,038 | 314,294,052 |
| **Хорогдуулсан нэгж хувьцаанд ноогдох ашгийг тогтооход хэрэглэгдсэн хувьцааны жигнэсэн дундаж тоо хэмжээ** | **343,180,038** | **314,294,052** |
| **Суурь болон хорогдуулсан нэгж хувьцаанд ногдох ашиг - төгрөг** | **24.29** | **34.41** |

## 15. Ногдол ашиг

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| Өмнөх жилийн үр дүнтэй холбоотой тайлант жилд нэгж энгийн хувьцаанд 4.62 төгрөгийн (2021: 7.36 төгрөг) ногдол ашиг зарлаж, олгосон | 1,583,557 | 2,522,722 |
| 2022 оны хагас жилийн үр дүнтэй холбоотой тайлант жилд нэгж энгийн хувьцаанд 4.60 төгрөгийн (2021: 5.14 төгрөг) ногдол ашиг зарлаж, олгосон | 1,578,069 | 1,752,953 |
| **Нийт дүн** | **3,161,626** | **4,275,675** |

## 16. Бараа материал

| | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Түүхий эд материал | 8,492,356 | 3,773,178 |
| Хагас боловсруулсан бүтээгдэхүүн | 4,034,022 | 1,035,710 |
| Сав баглаа | 3,279,662 | 3,235,675 |
| Сэлбэг хэрэгсэл | 2,545,143 | 1,985,383 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 1,687,045 | 1,342,130 |
| Замд яваа бараа | 1,254,601 | 987,076 |
| Хангамжийн материал | 384,240 | 520,205 |
| Барааны нөөц | (35,579) | (40,101) |
| **Нийт дүн** | **21,641,490** | **12,839,256** |

2022 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бараа материалын нөөц сангийн нөөцийн хөдөлгөөн дараах байдалтай байна.

| | 2022 он төгрөг | 2021 он төгрөг |
|---|---|---|
| **01 сарын 01** | **(40,101)** | **(40,346)** |
| Нэмж байгуулсан бараа материалын нөөц | - | - |
| Бараа материалын нөөцийн буцаалт[3] | 4,522 | 245 |
| **12 сарын 31** | **(35,579)** | **(40,101)** |

[3] – Нөөц сан байгуулсан бараа материалаас тайлант онд 4,522 (2021 он: 245) мянган төгрөгийн дансны үнэтэй сэлбэг хэрэгслийг үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварт хэрэглэсэн байна. Мөн өмнөх тайлант жилд бараа материалын нөөц дансаар дамжуулаагүй нийт 1,533 мянган төгрөгийн бараа материалыг шууд акталсан байна. Тэмдэглэл 8, Ерөнхий удирдлагын зардал – аас харах.

Тайлант жилийн 06 дугаар сарын 30 -ны өдрөөр буюу Макс – Агро ХХК -ийг Сүү ХК-тэй нэгтгэж өөрчилсөнтэй холбоотой бараа материал дансанд 654,888 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна. (Тэмдэглэл 26 )

## 17. Худалдааны болон бусад авлага

| | Лав | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|---|
| Худалдааны авлага | | 1,868,754 | 1,496,953 |
| Холбоотой талаас авах худалдааны авлага[4] | | 20,260 | 208,951 |
| Хасах нь: Худалдааны авлагын үнэ цэний бууралтын нөөц | (i) | (122,849) | (223,023) |
| **Худалдааны авлага, цэвэр** | | **1,766,165** | **1,482,881** |
| Холбоотой талуудаас бусад авах авлага [5] | | 138,269 | 6,703 |
| Бусад авлага | | 265,499 | 94,867 |
| Хасах: Үнэ цэний бууралтын нөөц | (ii) | (225,815) | - |
| **Хорогдуулсан өртгөөр ангилагдсан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнөөс бусад санхүүгийн хөрөнгө** | | **1,944,118** | **1,584,451** |
| Татварын авлага | | 1,742,874 | 554,085 |
| Бусад авлага | | 75,040 | - |
| **Нийт худалдааны болон бусад авлага** | | **3,762,032** | **2,138,536** |

[4] - Холбоотой талуудаас авах авлага нь сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалтаас үүссэн. (Тэмдэглэл 30, Холбоотой талуудын ажил гүйлгээ)
[5] - Холбоотой талуудаас авах бусад авлага нь тайлант жилд үндсэн хөрөнгө борлуулснаас үүссэн. (Тэмдэглэл 30, Холбоотой талуудын ажил гүйлгээ)

Хорогдуулсан өртгөөр ангилагдсан худалдааны болон бусад авлагын дансны үнэ цэн нь бодит үнэ цэнтэйгээ ойролцоо байна.

Тайлант жилийн 06 дугаар сарын 30-ны өдрөөр буюу Макс – Агро ХХК -ийг Сүү ХК-тэй нэгтгэж өөрчилсөнтэй холбоотой худалдааны болон бусад авлага дансанд цэвэр дүнгээр 13,369 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн байна. (Тэмдэглэл 26 )

### (i) Худалдааны авлагын хүлээгдэж буй зээлийн алдагдал

Компани худалдааны авлагын хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлын нөөцийг байгуулах СТОУС 9 -д заасан хялбаршуулсан аргыг ашигладаг. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг цуглуулагдах суурьиар хэмжихдээ худалдааны авлагын зээлийн эрсдэл болон насжилтад нь үндэслэн бүлэглэнэ.
Тайлант хугацаа бүрд худалдааны авлагууд нь үнэ цэний бууралтад орсон эсэхийг Компани үнэ цэний бууралтын матриц ашиглан үздэг. Сангийн матриц нь компанийн түүхэн мэдээлэл болох хугацаа хэтэрсэн хоногт суурилдаг. Компани түүхэн мэдээлэлд үндэслэсэн сангийн матрицыг ирээдүйд чиглэсэн тооцооллоор тохируулдаг. Тайлагналын өдөр бүр түүхэн чанаргүй болох магадлалын түвшнийг шинэчлэн ирээдүйд чиглэсэн тооцооллыг шинэчилдэг.

## 17. Худалдааны болон бусад авлага (*үргэлжлэл*)

2022 оны 12-р сарын 31-нээрх худалдааны авлага болон гэрээний хөрөнгийн нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдлын нөөц нь дараах байдалтай байна:

| 2022 оны 12 сарын 31 | 0-30 хоног хэтэрсэн мян.төг | 31-90 хоног хэтэрсэн мян.төг | 91-365 хоног хэтэрсэн мян.төг | 365 хоног хэтэрсэн мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|---|---|
| Хүлээгдэж буй алдагдлын түвшин | 0.06% | 0.15% | 67.19% | 100.00% | |
| Нийт дансны үнэ | 1,260,957 | 453,463 | 162,181 | 12,413 | **1,889,014** |
| Алдагдлын нөөц | 804 | 661 | 108,971 | 12,413 | **122,849** |

| 2021 оны 12 сарын 31 | 0-30 хоног хэтэрсэн мян.төг | 31-90 хоног хэтэрсэн мян.төг | 91-365 хоног хэтэрсэн мян.төг | 365 хоног хэтэрсэн мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|---|---|
| Хүлээгдэж буй алдагдлын түвшин | 0.07% | 0.16% | 100.00% | 100.00% | |
| Нийт дансны үнэ | 1,283,574 | 200,515 | 152,824 | 68,991 | **1,705,904** |
| Алдагдлын нөөц | 889.61 | 318 | 152,824 | 68,991 | **223,023** |

Худалдааны авлагын үнэ цэний бууралтын нөөцийн хөдөлгөөнийг доор харуулаа:

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| **01 сарын 01-ний үлдэгдэл** | **(223,023)** | **(319,938)** |
| Тайлант хугацаанд нэмэгдсэн нөөц | - | - |
| Худалдааны авлагын нөөцийн буцаалт | 100,174 | 96,915 |
| **12 сарын 31-ний үлдэгдэл** | **(122,849)** | **(223,023)** |

## 17. Худалдааны болон бусад авлага (*үргэлжлэл*)

### (ii) Бусад авлага ба холбоотой талуудаас авах авлагын үнэ цэний бууралтын нөөц

Холбоотой талуудаас авах авлага болон бусад авлагуудын хувьд СТОУС 9-д заасан ерөнхий аргачлалын дагуу хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолдог бөгөөд энэ нь зээлийн эрсдэлд томоохон өсөлт гарсан эсэх дээр суурилдаг. Компанийн дотоод үнэлгээний систем болон жилийн эцсийн авлагын ангилал дээр үндэслэн зээлийн чанар болон зээлийн эрсдэлийн хэмжээг доорх хүснэгтэд харуулав.

| 12 Сарын 31 | Шатлал 1<br>мян.төг | Шатлал 2<br>мян.төг | Шатлал 3<br>мян.төг | 2022 он<br>Нийт<br>мян.төг | 2021 он<br>Нийт<br>мян.төг |
|---|---|---|---|---|---|
| **Дотоод үнэлгээний зэрэг** | | | | | |
| Сайн | 100,272 | - | - | **100,272** | **101,570** |
| Хэвийн | - | 50,257 | - | **50,257** | **-** |
| Чанар муудсан | - | - | 253,239 | **253,239** | **-** |
| **Нийт** | **100,272** | **50,257** | **253,239** | **403,768** | **101,570** |
| Үнэ цэний бууралтын нөөц | - | - | (225,815) | **(225,815)** | **-** |
| **Цэвэр дүн** | **100,272** | **50,257** | **27,424** | **177,953** | **101,570** |

Бусад авлагын үнэ цэний бууралтын нөөцийн хөдөлгөөнийг доор харууллаа:

| | 2022 он<br>мян.төг | 2021 он<br>мян.төг |
|---|---|---|
| **01 сарын 01-ний үлдэгдэл** | **-** | **-** |
| Тайлант хугацаанд нэмэгдсэн нөөц | - | - |
| Бусад авлагын нөөцийн буцаалт | 244,239 | - |
| Маск - Агро ХХК -ийн нэгтгэлээр нэмэгдсэн | (470,054) | - |
| **12 сарын 31-ний үлдэгдэл** | **(225,815)** | **-** |

## 18. Холбоотой талуудад олгосон зээлийн авлага

| | Лав | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|---|
| Холбоотой талаас авах зээлийн авлага | | 571,495 | 6,136,076 |
| Хасах нь: Зээлийн авлагын үнэ цэний бууралтын нөөц | (iii) | - | (464,864) |
| **Зээлийн авлага, цэвэр** | | **571,495** | **5,671,212** |
| Хүүгийн авлага | | - | 191,676 |
| **Хорогдуулсан өртгөөр ангилагдсан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнөөс бусад санхүүгийн хөрөнгө** | | **571,495** | **5,862,888** |

**(iii) Холбоотой талуудад олгосон зээлийн авлага**

Холбоотой талуудад олгосон зээлийн авлагуудын хувьд СТОУС 9-д заасан ерөнхий аргачлалын дагуу хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолдог бөгөөд энэ нь зээлийн эрсдэлд томоохон өсөлт гарсан эсэх дээр суурилдаг.

| 12 Сарын 31 | Шатлал 1 мян.төг | Шатлал 2 мян.төг | Шатлал 3 мян.төг | 2022 он Нийт мян.төг | 2021 он Нийт мян.төг |
|---|---|---|---|---|---|
| **Дотоод үнэлгээний зэрэг** | | | | | |
| Сайн | 570,495 | - | - | **570,495** | **1,408,977** |
| Хэвийн | - | - | 1,000 | **1,000** | **4,918,775** |
| Чанар муудсан | - | - | - | **-** | **-** |
| **Нийт зээлийн авлага** | **570,495** | **-** | **1,000** | **571,495** | **6,327,752** |
| Үнэ цэний бууралтын нөөц | - | - | - | **-** | **(464,864)** |
| **Нийт цэвэр зээлийн авлага** | **570,495** | **-** | **1,000** | **571,495** | **5,862,888** |

## 18. Холбоотой талуудад олгосон зээлийн авлага (*үргэлжлэл*)

2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн холбоотой талуудаас авах авлага болон холбоотой талуудад олгосон зээлийн үнэ цэнийн бууралтын нөөцийн хөдөлгөөн нь дараах байдалтай байна:

| | 2022 он мян.төг | 2021 он мян.төг |
|---|---|---|
| **01 сарын 01-ний үлдэгдэл** | **(464,864)** | **(63,645)** |
| Тайлант хугацаанд нэмэгдсэн | - | (401,219) |
| Зээлийн авлагын нөөцийн буцаалт | 464,864 | - |
| **12 сарын 31-ний үлдэгдэл** | **-** | **(464,864)** |

## 19. Урьдчилж төлсөн төлбөр

| | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Урьдчилж гарсан зардал[(6)] | 709,537 | 574,780 |
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр[(7)] | 1,400,109 | 5,081,180 |
| Үндсэн хөрөнгө худалдаж авахаар төлсөн урьдчилгаа[(7)] | 169,988 | 4,226,084 |
| Үндсэн хөрөнгө олж бэлтгэхээр холбоотой талд төлсөн урьдчилгаа | - | 2,368,100 |
| **Нийт эргэлтийн урьдчилгаа** | **2,279,634** | **12,250,144** |
| Нэмэх нь: Эргэлтийн бус хэсэг[(8)] | 1,516,620 | 1,700,282 |
| **Нийт** | **3,796,254** | **13,950,426** |

[(6)] - Уг зардалд томилолт, даатгал, түрээсийн урьдчилж төлсөн зардлууд болон дараа тайлангийн тооцоонууд хамаарна.

[(7)] - Бараа материалаарх хөрөнгө болон эргэлтийн бус хөрөнгө олж эзэмшихтэй холбоотой аливаа бэлтгэн нийлүүлэгчид урьдчилж шилжүүлсэн буюу бараа материал, ажил үйлчилгээнд хүлээгдэж буй дүн.

[(7)] – Өмнөх онд холбоотой талд агуулахын байр бариулахаар урьдчилж төлсөн төлбөрийн дүнг багтсан. Тэмдэглэл 30, Холбоотой талуудын ажил гүйлгээ - ээс харах. (Тэмдэглэл 33 Мөнгөн гүйлгээний тайланг дэмжих тэмдэглэл)

[(8)] – Урьдчилж төлсөн төлбөр дансны эргэлтийн бус хэсгээр бүртгэлтэй байгаа дүн нь компанийн худалдан авагчтай байгуулсан гэрээ олж авахтай холбоотой 1 жилээс илүү хугацаанд хорогдож дуусах урьдчилж төлсөн зардлын дүнг илэрхийлнэ.

Тайлант жилийн эцсээр урьдчилгаа дансны үлдэгдэлд аливаа үнэ цэнийн бууралт байхгүй.

## 20. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

| | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Касс дахь бэлэн мөнгө | 130,673 | 30,035 |
| Банкин дахь харилцах данс | 2,088,954 | 6,891,738 |
| Богино хугацаат хадгаламж[9] | 23,326 | 95,719 |
| **Нийт дүн** | **2,242,953** | **7,017,492** |

[9] Компани 2022 оны 10 сарын 15 -ны өдөр 3 сарын хугацаатай хадгаламжийн гэрээг Хас банктай байгуулсан ба хадгаламжийн хүү жилийн 7.4 % болно.

12 сарын 31-ний өдрөөрх мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлийг үндсэн валютаар илэрхийлбэл:

| | 2022 оны 12 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Төгрөг | 865,718 | 6,825,264 |
| Ам доллар | 1,231,685 | 10,637 |
| Евро | 139,381 | 108,053 |
| Юань | 5,910 | - |
| Рубль | 259 | 73,538 |
| **Нийт дүн** | **2,242,953** | **7,017,492** |

## 21. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө

***Ерөнхий Тодорхойлолт***

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 08-р сарын 17-ны өдрийн тогтоол № 05-ийн дагуу ашиг шимийн үзүүлэлт буурсан болон эрүүл мэндийн хувьд эдгэрэх боломжгүйгээр өвчилсөн зарим биологийн хөрөнгүүдийг худалдан борлуулах, актлахаар тодорхойлсон байгаагаас 2022 оны 12-р сарын 31-ний өдөөр тасалбар болсон жилийн эцэст үлдсэн дээрх хөрөнгүүдийг борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөд ангилсан.

## 21. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (*үргэлжлэл*)

12 сарын 31- ний өдрөөрх санхүүгийн байдлын тайланд борлуулахаар эзэмшиж буй гэж ангилсан:

| **Биологийн хөрөнгө** | | **2022 он** |
|---|---|---|
| | **Тоо толгой** | **Бодит үнэ цэн мян.төг** |
| Макс Агро ХХК -н нэгтгэлээр нэмэгдсэн (Тэмдэглэл26) | 33 | 77,947 |
| Борлуулсан | (6) | (10,482) |
| Ангилал залруулсан | 1 | 350 |
| Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгөөс хүлээсэн гарз | - | (2,375) |
| **Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө** | **28** | **65,440** |

***Үнэ цэнийн бууралтын гарз***

Эргэлтийн бус биологийн хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөөр ангилах үеийн бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн болон дансны үнийн аль багаар хэмжих үед үүссэн 8,196 мянган төгрөгийн үнэ цэний бууралтын гарзыг хүлээн зөвшөөрч, биологийн хөрөнгийн бодит үнэ цэний гарзад тусгасан.

***Бодит үнэ цэний хэмжилт***

Компанийн борлуулах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийг Түвшин 3-ийн тогтмол бус бодит үнэ цэний хэмжилтээр ангилсан.
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлоход хэрэглэсэн үнэлгээний арга техник ба нөлөө бүхий үл ажиглагдахуйц өгөгдлийг доор хураангуйлан харууллаа:

| **Хэрэглэсэн үнэлгээний техник** | **Нөлөө бүхий үл ажиглагдахуйц өгөгдөл** |
|---|---|
| ***Цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэний арга (Орлогын хандлага)***<br>*Энэхүү арга нь хөрөнгийн үнэ цэнийг түүний ирээдүйд олох цэвэр мөнгөн орлогод үндэслэн өнөөгийн бодит үнэ цэнийг нь тооцоолдог арга хандлага юм.* | *Нэгж хөрөнгөд ногдох мөнгөн зардал болон мөнгөн орлогын урсгалыг тооцоолон компанийн капиталын жинлэсэн дундаж өртгөөр (15.02%) цэвэр мөнгөн урсгалыг дискаунтчилах замаар бодит үнэ цэний тооцоолол хийсэн. Өмнөх жилүүдийн түүхэн мэдээлэлд үндэслэн үнээний саалинд байх дундаж хугацааг 62%, нэг үнээний жилийн саалийн гарцыг 3,650 литр байхаар тооцсон.* |

Үнэлгээний арга техникт тайлант жилд ямар нэгэн өөрчлөлт ороогүй. Бодит үнэ цэний хэмжилт нь дээр дурдсан зүйлсийн хамгийн сайн хэрэглээнд суурилсан бөгөөд энэ нь бодит хэрэглээнээс зөрүүтэй байж болно.

## 22. Өмч, барилга, тоног төхөөрөмж

| *(i) Өртөг* | Барилга, байгууламж | Тавилга, эд хогшил | Компьютер дагалдах хэрэгсэл | Тээврийн хэрэгсэл | Машин, тоног төхөөрөмж | Дуусаагүй барилга[10] | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг |
| **2021 оны 01 сарын 01** | **7,805,649** | **2,118,054** | **388,122** | **5,213,105** | **24,217,925** | **2,396,941** | **42,139,796** |
| Худалдаж авсан | 5,504,087 | 59,526 | 71,003 | 1,027,832 | 730,159 | 2,060,350 | **9,452,957** |
| Дахин ангилсан | 344,333 | - | - | 55,616 | 2,098,372 | (2,498,321) | **-** |
| Данснаас хассан | - | (7,236) | (550) | (132,189) | (797,695) | - | **(937,670)** |
| Борлуулсан | - | - | (2,509) | (359,419) | - | - | **(361,928)** |
| **2021 оны 12 сарын 31** | **13,654,069** | **2,170,344** | **456,066** | **5,804,945** | **26,248,761** | **1,958,970** | **50,293,155** |
| Худалдаж авсан | 351,595 | 21,440 | 135,011 | 4,920,535 | 524,445 | 9,819,763 | **15,772,789** |
| Макс Агро ХХК -н нэгтгэлээр нэмэгдсэн (Тэмдэглэл26) | 8,624,152 | 67,837 | 27,612 | 77,889 | 4,148,306 | 1,173,970 | **14,119,766** |
| Дахин ангилсан | 8,938 | - | - | - | 2,939,366 | (2,948,304) | **-** |
| Данснаас хассан | - | (2,720) | - | - | (2,555,333) | - | **(2,558,053)** |
| Борлуулсан | - | (2,302) | (7,362) | (611,735) | (144,664) | - | **(766,063)** |
| **2022 оны 12 сарын 31** | **22,638,754** | **2,254,599** | **611,327** | **10,191,634** | **31,160,881** | **10,004,399** | **76,861,594** |

*Хүснэгтийн үргэлжлэлийг дараагийн хуудаснаас үзнэ үү*

## 22. Өмч, барилга, тоног төхөөрөмж (*үргэлжлэл*)

| ***(ii) Хуримтлагдсан элэгдэл*** | **Барилга, байгууламж** | **Тавилга, эд хогшил** | **Компьютер дагалдах хэрэгсэл** | **Тээврийн хэрэгсэл** | **Машин, тоног төхөөрөмж** | **Дуусаагүй барилга[10]** | **Нийт** |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** |
| **2021 оны 01 сарын 01** | **(2,022,406)** | **(945,946)** | **(302,817)** | **(2,035,043)** | **(12,137,745)** | **-** | **(17,443,957)** |
| Байгуулсан элэгдэл | (231,966) | (191,196) | (54,108) | (546,241) | (2,323,856) | - | **(3,347,367)** |
| Данснаас хассан | - | 6,691 | 550 | 113,452 | 708,964 | - | **829,657** |
| Борлуулсан | - | - | 482 | 317,729 | - | - | **318,211** |
| **2021 оны 12 сарын 31** | **(2,254,372)** | **(1,130,451)** | **(355,893)** | **(2,150,103)** | **(13,752,637)** | **-** | **(19,643,456)** |
| Байгуулсан элэгдэл | (574,620) | (188,815) | (21,226) | (648,041) | (1,795,310) | - | **(3,228,012)** |
| Макс Агро ХХК -н нэгтгэлээр нэмэгдсэн (Тэмдэглэл26) | (2,222,646) | (48,924) | (26,037) | (41,197) | (2,111,152) | - | **(4,449,956)** |
| Дахин ангилсан | (4,766) | - | - | - | 4,766 | - | **-** |
| Данснаас хассан | - | 2,087 | - | - | 2,555,327 | - | **2,557,414** |
| Борлуулсан | - | 1,932 | 7,362 | 424,646 | 102,410 | - | **536,350** |
| **2022 оны 12 сарын 31** | **(5,056,404)** | **(1,364,171)** | **(395,794)** | **(2,414,695)** | **(14,996,596)** | **-** | **(24,227,660)** |
| ***(iii) Дансны цэвэр үнэ*** | | | | | | | |
| **2021 оны 01 сарын 01** | **5,783,243** | **1,172,108** | **85,305** | **3,178,062** | **12,080,180** | **2,396,941** | **24,695,839** |
| **2021 оны 12 сарын 31** | **11,399,697** | **1,039,893** | **100,173** | **3,654,842** | **12,496,124** | **1,958,970** | **30,649,699** |
| **2022 оны 12 сарын 31** | **17,582,350** | **890,428** | **215,533** | **7,776,939** | **16,164,285** | **10,004,399** | **52,633,934** |

## 22. Өмч, барилга, тоног төхөөрөмж (*үргэлжлэл*)

(10) - Дуусаагүй барилга дансны үлдэгдэл нь ашиглалтад ороход бэлэн болоогүй үйлдвэрийн тоног төхөөрөмж буюу үйлдвэрийн шугамын хуримтлуулсан зардал болон баригдаж байгаа үхрийн байрны дүнг илэрхийлнэ. Хөрөнгийг иж бүрэн барьж дуусгаж, ашиглахад бэлэн болсны дараагаар ирээдүйд тухайн хөрөнгөнөөс бий болох өгөөжийн хугацаанд элэгдүүлнэ.

Компани өөрийн эзэмшлийн үндсэн хөрөнгийг зээлийн барьцаанд барьцаалсан бөгөөд эдгээр барьцаалсан хөрөнгөтэй холбоотой аливаа үнэ цэний бууралтын шинж тэмдэг байхгүй. Барьцаалсан хөрөнгийн дэлгэрэнгүй жагсаалтыг Тэмдэглэл 28, Зээл болон өр төлбөр - өөс үзнэ үү

Тайлант жилд үндсэн хөрөнгө дансанд капиталжуулсан зээлийн хүү 687,375 (2021 он: 119,108) мянган төгрөг байна. Тэмдэглэл 12 болон 33.

## 23. Түрээс

**Түрээсийн үйл ажиллагааны шинж чанар (түрээслэгч талын хувьд)**

Компани нь Улаанбаатар хот дах оффисын талбайгаа түрээсэлдэг ба сар бүрийн тогтмол түрээсийн төлбөртэй. Түрээсийн гэрээ нь компанийн холбоотой тал болох Макс Импекс ХХК -тай байгуулсан гэрээ ба анх 2019 оны 1 дүгээр сарын 01 -ний өдрөөс эхлэн СТОУС 16-ыг анх мөрдөж түрээсийн тогтмол төлбөрийг дискаунтчилан тооцож Түрээсийн өр төлбөр болон Ашиглах эрхтэй хөрөнгө хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Компани үндсэн үйл ажиллагааны орлого олдог нэг суваг болох томоохон сүлжээ дэлгүүрүүдэд худалдааны талбай түрээслэх гэрээгээр борлуулалтын үйл ажиллагаа явуулдаг. Түрээсийн гэрээг жил бүр шинэчилж хийдэг ч гэсэн компанийн орлого олох томоохон эх үүсвэр учир удирдлагын зүгээс анх 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2 жилийн хугацаатай гэрээг үнэлсэн ба 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дахин 2 жилийн хугацаагаар хөтөлбөрт өөрчлөлт оруулан түрээсийн гэрээ тус бүрийг нэмж үнэлэн санхүүгийн тайланд Түрээсийн өр төлбөр болон Ашиглах эрхтэй хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Тайлант онд түрээсийн гэрээний төлбөр болон хугацаанд өөрчлөлт орж, өөрчлөлт орсон өдрөөс түрээсийн гэрээнүүдийг дахин үнэлж бүртгэсэн. Түрээсийн төлбөр нь тогтмол болон хувьсах түрээснээс бүрддэг бөгөөд тогтмол түрээсийн хувьд анхны хэмжилтээр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Хувь хэмжээ ба индексээс хамаардаггүй хувьсах түрээсийн хувьд зардал гарсан тухай бүрд нь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Компани нь нийлүүлээгүй бараа үйлчилгээнд урьдчилж хүлээж авсан төлбөрийн дүнгээр гэрээний өр төлбөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Тайлант үе бүрийн эцэст гэрээний орлого иж бүрэн болсон дүнгээр гэрээний өр төлбөрийг бууруулж, тайлант хугацааны орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Жижиглэнгийн дэлгүүрүүдэд бараа бүтээгдэхүүнийг борлуулах гэрээний нөхцөлд л захиалга хүлээн авсан үедээ урьдчилан төлбөрийг хүлээн авахаар заасан байдаг хэдий ч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх хугацаа нь заримдаа тухайн захиалга өгсөн өдөр ч байх тохиолдол байдаг. Гэрээний үлдэгдэл санхүүгийн бүртгэлд үлдэх нь ховор байдаг байна. Тиймээс бараа борлуулалттай холбоотой гэрээт эрх үүсдэггүй учир гэрээний өр төлбөр хүлээн зөвшөөрсөн дүн нь материаллаг дүн биш байдаг. Гэрээг биелүүлэхтэй холбоотой гарсан хэргэгч, хөлдөөгчийн зардлыг хөрөнгөөр хүлээн зөвшөөрч хөрөнгийн нийт ашиглалтын хугацааны турш зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

*Практик чөлөөлөлт*

Компани нь амласан бараа, үйлчилгээг худалдан авагчид нийлүүлсэн өдөр ба уг бараа, үйлчилгээний үнийг худалдан авагч төлөх өдрийн хоорондох хугацаа нь нэг жил буюу түүнээс богино байна гэж хүлээж байгаа учир санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсгийн нөлөөллийг практик чөлөөлөлт болгон аливаа тохируулга хийхгүй байх сонголтыг хийсэн.

***Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба үйл ажиллагааны зардлууд***

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба үйл ажиллагааны зардлууд нь тайлант хугацааны үед өөрийн хөрөнгийг бууруулж буй хөрөнгө оруулагчдад олгосон хуваарилалтаас бусад гадагшлах урсгал, хөрөнгийн бууралт, мөн өр төлбөрийн нэмэгдэл зэрэг болно. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг, борлуулалтын зардал, ерөнхий болон удирдлагын зардал, бусад зардал, ба санхүүгийн зардлуудыг гарсан үед нь ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

***Санхүүгийн бус хөрөнгө үнэ цэнийн бууралт***

Өмч, барилга, тоног төхөөрөмж, биет бус хөрөнгө зэрэг бусад санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэ нь эргэн нөхөгдөхгүй байж болохыг илэрхийлсэн үйл явдал буюу өөрчлөлт тухайн нөхцөлд байгаа эсэхийг шалгаж үзэх ёстой. Хөрөнгийн дансны үнэ нь эргэн нөхөгдөх дүнгээс (ашиглалтын үнэ ба бодит үнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнгээс их) давсан үед хөрөнгийг бууруулах бичилт хийдэг. Тухайлсан хөрөнгийн нөхөгдөх үнийг тооцоолох боломжгүй байх тохиолдолд хөрөнгүүдийг бие даан тодорхой мөнгөн урсгал бий болгохгүй хөрөнгийн бүлгийн хамгийн бага нэгж болгох хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн хувьд үнийн бууралтыг шалгана.

## 34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (*үргэлжлэл*)

***Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт*** (*үргэлжлэл*)

Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын алдагдал нь мөнгө бий болгогч нэгжүүдэд хуваарилагдсан анхны дансны нийт үнийн дүнг бууруулна. Үнэ цэнийн бууралтын алдагдлын үлдэгдэл хэсэг нь бусад хөрөнгийн хамрах мөнгө бий болгогч нэгжүүдэд хувь тэнцүүлэн тооцоологдоно. Дараа үеүдэд бүх хөрөнгийн өмнө нь бүртгэгдсэн үнэ цэнийн бууралтын гарз байгаа эсэхийг дахин шалгах бөгөөд энэ магадгүй удаан хугацаанд оршин тогтнохгүй байж болно. Үнэ цэнийн бууралтын төлбөрийг хэрвээ мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүн нь үүний дансны үнээс давсан бол дахин өөрчлөгдөнө. Үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг.

***Гадаад валютаарх ажил гүйлгээ***

Компанийн үйл ажиллагаа эрхэлдэг үндсэн эдийн засгийн орчны валютаас (бүртгэлийн валют) бусад валютаар илэрхийлэгдсэн ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлсэн.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөөрх хөрөнгө, өр төлбөрийг бүртгэлийн тайлангийн өдрийн албан ханшаар хөрвүүлсэн. Мөнгөөрх төлөгдөөгүй хөрөнгө, өр төлбөрийг дахин хөрвүүлснээс үүссэн ханшийг зөрүүг ашиг, алдагдалд шууд тусгасан.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгөөр нь илэрхийлж гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлсэн.

Борлуулахад бэлэн мөнгөөрх санхүүгийн хөрөнгийг дахин хөрвүүлснээс үүсэн ханшийн зөрүүний олз, гарзыг бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бүрэлдэхүүн хэсэг гэж үзсэн бөгөөд ашиг, алдагдалд тусгасан. Харин борлуулахад бэлэн мөнгөн бус санхүүгийн хөрөнгийн ханшийн зөрүүний олз, гарзыг тухайн санхүүгийн хэрэглүүртэй хамаатай гэж үзэж нийт олз, гарзтай нь хамт хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

| Валют | Дундаж ханш | | Хаалтын ханш | |
|---|---|---|---|---|
| | 2022 он | 2021 он | 2022 оны 12 сарын 31 | 2021 оны 12 сарын 31 |
| Ам.доллар | 3,141.40 | 2,849.25 | 3,444.6 | 2,848.80 |
| Евро | 3,303.03 | 3,371.66 | 3,669.02 | 3,222.99 |
| Юань | 466.44 | 441.69 | 495.4 | 447.15 |
| Рубль | 47.27 | 40.31 | 48.85 | 38.34 |
| Иен | 23.96 | 23.86 | 26.07 | 24.74 |

## 34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (*үргэлжлэл*)

***Санхүүгийн хөрөнгө***

Хөрөнгө худалдан авсан зорилгоос хамаарч компани санхүүгийн хөрөнгийг доор дурдсан төрлүүдийн нэгээр нь ангилдаг. Хейджийн харилцааны шаардлага хангасан санхүүгийн хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийг компани дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу ангилна:

*Бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар хэмжигдэх*

Бодит үнэ цэн нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөд мөнгөөр төлөгдөх үүсмэл хэрэглүүр болон цаг хугацааны үнэ цэний нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болсон мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр багтана (өр төлбөрөөр ангилагдсан мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүрийн тухай 'Санхүүгийн өр төлбөр' хэсгээс харна уу). Энэхүү ангилалд багтсан санхүүгийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэний өөрчлөлтийг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн орлого эсвэл зардлын мөрөнд тусгана. Хейджийн хэрэглүүрийн зориулалтгүй үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусдаар компанид арилжаалах зорилготой санхүүгийн хөрөнгө байхгүй бөгөөд компани санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг сайн дураараа ашиг, алдагдлаар хэмжигдэх ангилалд оруулдаггүй байна.

*Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх*

Эдгээр хөрөнгө нь харилцагчид хүргэх бараа болон үйлчилгээний нөөцөөс (худалдааны авлага гэх мэт) ихэвчлэн үүсдэг. Гэхдээ мөн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд гэрээний мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрөөс бүрддэг бусад төрлийн санхүүгийн хөрөнгөөс үүсдэг. Эдгээрийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэн дээр тэдгээрийг олж авах эсвэл гаргахтай холбоотой шууд хамааралтай гарсан ажил гүйлгээний зардлыг нэмж бүртгэх ба дараа үед үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон үнэ цэний бууралтыг хассан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Компанийн хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгө нь санхүүгийн байдлын тайлан дахь худалдааны болон бусад авлага болон мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бүрдэнэ. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд касс дахь бэлэн мөнгө, банкин дахь хадгаламж, 3 сар болон түүнээс богино хугацаатай түргэн хөрвөх бусад хөрөнгө оруулалт багтана.

*Бодит үнэ цэн нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх*

Компани нь охин компани, хараат компани эсвэл хамтын хяналттай аж ахуйн нэгжид багтаагүй, арилжаалах зорилгоор эзэмшдэггүй, хувьцаат болон хувьцаат бус аж ахуйн нэгж дэх стратегийн зорилго бүхий хөрөнгө оруулалт эзэмшиж байгаа тохиолдолд бодит үнэ цэн нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх хөрөнгө оруулалтаар ангилна. Эдгээрийг бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд бодит үнэ цэний өөрчлөлтийг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэх ба бодит үнэ цэн нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх нөөцөд хуримтлуулна. Бодит үнэ цэн нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх нөөцийн үлдэгдлийг данснаас хасах замаар ашиг, алдагдал руу ангилахгүй ба харин шууд хуримтлагдсан ашиг руу ангилна.

## 34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (*үргэлжлэл*)

***Санхүүгийн хөрөнгө** (үргэлжлэл)*

Хөрөнгө оруулалтын өртгийн хэсгийг илэрхий нөхөх ногдол ашгаас бусад ногдол ашгийн хувьд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Харин уг тохиолдолд ногдол ашгийг бүхэлд нь эсвэл зарим хэсэг нь холбогдох хөрөнгө оруулалтын дансны үнээс хасаж бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгийн худалдан авалт болон борлуулалтыг бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх бодит үнэ цэнээр нь тохиролцоо хийсэн өдрөөр хэмжих ба арилжааны өдөр болон тохиролцоо хийсэн өдөр хоорондын бодит үнэ цэний аливаа өөрчлөлтийг бодит үнэ цэн нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх нөөцөд хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэний бууралт

Компани худалдааны авлагын үнэ цэний бууралтын нөөцийг СТОУС 9-д заасан хялбаршуулсан арга-д үндэслэн нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тодорхойлох замаар нөөцийн байгуулдаг. Ингэхдээ худалдааны авлагын төлөгдөхгүй байх магадлалыг үнэлдэг. Худалдааны авлагын нийт хугацааны туршид авлага төлөгдөхгүй байхаас үүсэх хүлээгдэж буй алдагдлыг тодорхойлж уг хүлээгдэж буй алдагдлыг энэхүү магадлалаар үржүүлж тооцно. Худалдааны авлагын хувьд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн гарзын бүртгэгдсэн нөөцийн данстай цэвэр дүнгээр тайлагнана. Худалдааны авлагыг цуглуулж чадахгүй гэдгийг баталгаажуулснаар хөрөнгийн нийт дансны үнийг холбогдох нөөцтэй нь цэвэрлэж данснаас хасна.

Бусад авлага, холбоотой талуудаас авах авлага болон холбоотой талуудад олгосон зээлд байгуулсан үнэ цэний бууралтын нөөцийг хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвараар урьдчилан таамагласны үндсэн дээр тооцоолно. Нөөцийн дүнг тодорхойлохдоо ашигласан аргачлал нь санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гарсан эсэхэд үндэслэнэ. Санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гараагүй бол 12 сарын хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нийт хүүгийн орлоготой нь хамт хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гарсан бол нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нийт хүүгийн орлоготой нь хамт хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үнэ цэний бууралт үүссэн гэж тогтоогдвол нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүүгийн орлоготой нь хамт цэвэр сууриар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

- Санхүүгийн хэрэглүүрийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гарсан эсэхийг тус санхүүгийн хэрэглүүрийн үлдэх хугацааны туршид зээлийн чанаргүйдэх эрсдэл нь хэрхэн өөрчлөгдөхийг харгалзан үзэж шийдвэрлэнэ. Үүнийг үндэслэн санхүүгийн хөрөнгийг Шатлал 1, Шатлал 2, Шатлал 3 зэрэгт бүлэглэсэн болно. Шатлал 1: Санхүүгийн хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрөхөд үнэ цэний бууралтыг 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалд суурилан тооцно. Авлага эргэн төлөгдөх хугацаа хэтрээгүй болон 30 хоног дотор хугацаа хэтрэлттэй авлагыг энэ түвшинд ангилна. Шатлал 1-т мөн зээлийн эрсдэл нь сайжирч, Шатлал 2-оос шилжиж ирсэн санхүүгийн хөрөнгө багтана.
- Шатлал 2: Санхүүгийн хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт ажиглагдсан хөрөнгөд тухайн хөрөнгийн үнэ цэний бууралтыг Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалд суурилан тооцно. Авлага төлөгдөх хугацаанаас 31-90 хоногоор хугацаа хэтрэлтэд орсон тохиолдолд удирдлага уг авлагын зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт ажиглагдсан гэж үзэн Шатлал 2-т ангилдаг. Шатлал 2-т мөн зээлийн эрсдэл нь сайжирч, Шатлал 3-аас шилжиж ирсэн санхүүгийн хөрөнгө багтана.

## 34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (*үргэлжлэл*)

***Санхүүгийн хөрөнгө** (үргэлжлэл)*

- Шатлал 3: Санхүүгийн хөрөнгө нь чанаргүй төлөвт орсон бөгөөд үнэ цэний бууралтыг нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалд суурилан тооцдог санхүүгийн хөрөнгө багтана. Тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлөх нэг эсвэл түүнээс олон үйл явдал үүссэн тохиолдолд удирдлага авлагыг чанаргүйдсэн гэж үздэг бөгөөд Шатлал 3-т ангилна.

Компани нь хүлээгдэж буй бэлэн мөнгөний хомсдолыг хэмжихийн тулд ирээдүйд чиглэсэн макро эдийн засгийн хувилбаруудыг болон тэдгээрийн магадлалын жинг үндэслэн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолно. Бэлэн мөнгөний хомсдол нь гэрээний дагуу байгууллагын авахаар тохирсон мөнгөн урсгалын болон байгууллагын цуглуулахаар хүлээж буй мөнгөн урсгалын хоорондох зөрүүг хэлнэ. ХБЗА-ын тооцооллын аргачлал болон гол элементүүдийг дор үзүүлэв. Үүнд:

- Чанаргүйдлийн магадлал ('ЧМ) нь тодорхой цаг хугацааны туршид хөрөнгийн чанаргүйжих магадлалыг илэрхийлнэ. Өмнөх нь үл хүлээн зөвшөөрөгдөөгүй ба санхүүгийн тайлангийн өдөр багцад хэвээр байгаа тохиолдолд зээлийг үнэлэх хугацааны туршид зээл нь хэзээд чанаргүйжиж болно.
- Чанаргүйдэлд өртөх дүн ('ЧӨД) нь үндсэн үлдэгдэл ба хүүгийн эргэн төлөлт, зээлийн төлбөрийн хоцролт дээр хуримтлагдсан хүү гэх мэт тайлагналын өдрийн дараа бүртгэлийн дүнд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан үзэж ирээдүйд чанаргүй болох өдрийн хүлээгдэж буй зээлийн бүртгэлийн дүнг хэлнэ.
- Алдагдалд хүргэх чанаргүйдэл ('АХЧ') нь өгөгдсөн хугацаанд санхүүгийн хөрөнгө нь чанаргүй болсны улмаас хүлээх алдагдлын ойролцоолсон тооцоолол юм. Энэ нь гэрээний дагуу тохирсон мөнгөн гүйлгээний дүн болон Компанийн авахаар хүлээж буй дүн хоорондын зөрүүнд үндэслэнэ. АХЧ нь ихэвчлэн ЧӨД-ийн хувиар илэрхийлэгддэг.

Удирдлага түүхэн АХЧ-ыг тайлант үе бүр гурван жилийн түүхэн мэдээлэлд үндэслэн дараах томьёогоор тооцоолдог: АХЧ=1-(360 хоногоос дээг хугацаа хэтрэлттэй авлагын эргэн төлөлт/360 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй авлагын дүн)

***Санхүүгийн өр төлбөр***

Өр төлбөрийг олж авсан зорилгоос хамаарч компани санхүүгийн өр төлбөрийг доор дурдсан хоёр төрлийн аль нэгээр нь ангилдаг. Хейджийн харилцааны шаардлага хангасан санхүүгийн өр төлбөрөөс бусад санхүүгийн өр төлбөрийг компани дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу ангилна:

*Бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар хэмжигдэх*

Бодит үнэ цэн нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт цаг хугацааны үнэ цэний нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болоогүй мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр багтана (цаг хугацааны үнэ цэний нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болсон мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр болон мөнгөөр төлөгдөх үүсмэл хэрэглүүрийн тухай 'Санхүүгийн хөрөнгө' хэсгээс харна уу). Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэний өөрчлөлтийг  ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Компани ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах (хейдж) зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж, гаргадаг.

## 34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (*үргэлжлэл*)

***Санхүүгийн өр төлбөр** (үргэлжлэл)*

*Бусад санхүүгийн өр төлбөр*

Бусад санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс багтана:

- Банкны зээлийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой гүйлгээний зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцсон хорогдуулсан өртгөөр хэмждэг. Ингэснээр санхүүгийн байдлын тайлангаарх өр төлбөрийн үлдэгдэлд хүүгийн зардлыг эргэн төлөлтийн хугацааны турш тогтмол хувиар тооцоолох боломжийг олгодог. Санхүүгийн өр төлбөр бүрийн зорилгын хувьд хүүгийн зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү эсвэл купоны өглөг багтаадаг.
- Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн худалдааны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан.

***Хувьцаат капитал***

Компанийн гаргасан санхүүгийн хэрэгслүүд санхүүгийн өр төлбөр, хөрөнгийн шалгуурыг хангахгүй байх тохиолдолд л тэднийг өмчөөр ангилна. Компани энгийн хувьцаагаа өмчийн хэрэглүүр гэж ангилж нэрлэсэн үнээр бүртгэнэ. Хувьцааг нэрлэсэн үнээс нэмэгдэлтэй үнээр зарсан тохиолдолд нэрлэсэн үнээс илүү гарсан хэсгийг нэмж төлөгдсөн капиталаар бүртгэнэ. Өөрийн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой гүйлгээний зардлыг татвар суутгасан дүнгээр нь өөрийн хөрөнгөөс хасна.

***Халаасны хувьцаа***

Компани халаасны хувьцааг нэрлэсэн үнийн аргаар бүртгэлд тусгадаг. Халаасны хувьцааг худалдан авах болон арилжаалахад үүссэн кредитийг Халаасны хувьцааны Нэмж төлөгдсөн капиталд бичих ба кредит дүнгээс илүү гарсан дебит дүнг хуримтлагдсан ашиг руу бичнэ.

***Ногдол ашиг***

Ногдол ашиг нь хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан хөрөнгө оруулалтын өгөөжийн татан авалт юм. Ногдол ашиг олгох эсэх болон нэгж хувьцаанд хэдэн төгрөгийн ногдол ашиг олгохыг компанийн хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр тогтоох бөгөөд түүний зарласан тайлант хугацаанд нь өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

***Зээлийн өртөг***

Хугацаа шаардсан хөрөнгийн худалдаж авах, барьж байгуулах, үйлдвэрлэхтэй шууд холбоотой зээлийн зардлыг тухайн хөрөнгө иж бүрэн, ашиглахад бэлэн болох хүртэлх хугацаанд капиталжуулдаг. Тухайн зорилгоор авсан зээлтэй холбоотой хүүгийн түвшин эсвэл компанийн зээлийн ерөнхий эх үүсвэр нь ашиглагдаж буй бол жигнэсэн дундаж хүүгийн түвшнээр санхүүгийн зардлыг капиталжуулдаг. Зээлийн өртгийн капиталжуулалт нь хөрөнгийн барьж босгох үйл явц зогссон үед дуусдаг. Бусад зээлийн өртөг нь тухайн зардал гарсан үеийн хугацаандаа санхүүгийн зардалд тайлагнагддаг.

## 34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (*үргэлжлэл*)

***Түрээс***

*Түрээсийг тодорхойлох*

СТОУС 16 Түрээсийн анхны хэрэглээний өдөр болох 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш дараах бодлогуудыг мөрдсөн.

Гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь төлбөрийн хариуд хөрөнгийг ашиглах эрхийг тодорхой хугацааны турш олгодог бол түүнийг Компани түрээс гэж үздэг.

Түрээс гэдэг нь дараах шалгууруудыг хангасан гэрээ юм:
(а) Тодорхойлсон хөрөнгөтэй;
(б) Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг Компани хүртдэг; ба
(в) Компани хөрөнгийг ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй.

Бэлтгэн нийлүүлэгч тухайн түрээсийн хөрөнгийг солих, орлуулах эрхтэй эсэхийг Компани харгалзан үзэх ба хэрэв тийм бол тухайн гэрээг түрээсийн гэрээ гэж үзэхгүй. Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг Компани хүртэх эрхтэй эсэхийг тодорхойлохдоо Компани нь хууль ёсны эзэмшил эсвэл бусад боломжит үр өгөөжтэй хамааралтай бус харин зөвхөн хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн үр өгөөжийг л авч үзнэ.

Компани нь хөрөнгийн ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй эсэхийг тодорхойлохдоо ашиглалтын хугацааны туршид хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахаа удирдан чиглүүлэх эрхтэй эсэхийг харгалзан үзнэ.

*Түрээсийн хөрөнгө, өр төлбөрийн хэмжилт*

Хөрөнгийн шинж чанарын улмаас шийдвэр нь урьдчилан тодорхойлогдсон тул тухайн хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахтай холбоотой хамгийн их хамааралтай шийдвэр гаргахгүй байх үед Компани нь хөрөнгийн загварыг гаргах үед ашиглалтын хугацааны турш хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахыг урьдчилан тодорхойлох байдлаар оролцсон эсэхийг харгалзан үзнэ. Хэрэв гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь эдгээр шалгуурыг хангахгүй бол Компани СТОУС 16-гаас бусад холбогдох СТОУС-ын мөрдөнө.

Дараах түрээснээс бусад бүх түрээсийг ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөр хүлээн зөвшөөрөх замаар бүртгэнэ:
- Бага үнэ цэнтэй хөрөнгийн түрээс; ба
- 12 сар эсвэл түүнээс бага хугацаатай түрээс.

Түрээслүүлэгчид төлөх гэрээний төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээсийн өр төлбөрийг хэмжинэ. Түрээсийн нуугдмал хүүгийн түвшнийг шууд тодорхойлох боломжит бол уг түвшнийг ашигласнаар түрээсийн төлбөрийг дискаунтчилна. Хэрэв тэрхүү түвшнийг шууд тодорхойлох боломжгүй бол Компанийн зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшнийг ашиглана.

Зөвхөн индекс эсвэл хувь хэмжээнээс хамааралтай л бол түрээсийн хувьсах төлбөрийг түрээсийн өр төлбөрийн хэмжилтэд оруулна. Ийм үед түрээсийн өр төлбөрийг анх хэмжихдээ хувьсах элементүүд нь түрээсийн хугацаанд өөрчлөгдөхгүй гэж төсөөлдөг. Түрээсийн бусад хувьсах төлбөрүүдийг гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

## 34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (*үргэлжлэл*)

***Түрээс** (үргэлжлэл)*

Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед түрээсийн өр төлбөрийн дансны үнэд дараах зүйлс багтана:
- үлдэх өртгийн баталгааны дагуу төлөхөөр хүлээгдэж буй дүн;
- худалдан авах сонголтоо Компани хэрэгжүүлэх нь ул үндэслэлтэйгээр тодорхой бол тэрхүү сонголтыг хэрэгжүүлэх үнэ;
- түрээсийг цуцлах сонголтоо хэрэгжүүлэх талаар тухайн түрээсийн нөхцөлд тусгадаг бол түрээсийг цуцалсны улмаас төлөх торгуулийн дүн.

Ашиглах эрхтэй хөрөнгийг анх хэмжихдээ түрээсийн өр төлбөрийн дүнгээс аливаа түрээсийн урамшууллыг хасаж, дараах зүйлсийг нэмж тооцно:
- түрээсийн эхлэл өдөр эсвэл түүнээс өмнө төлсөн түрээсийн төлбөрүүд;
- компанийн гаргасан анхны шууд зардал; ба
- түрээсийн хөрөнгийг буулгаж нураах, ходуулж зайлуулах эсвэл нөхөн сэргээхийг гэрээгээр шаардсан бол түүнтэй холбоотой компанийн хүлээн зөвшөөрөх нөөцийн дүн.

Анхны хэмжилтийн дараа түрээсийн өр төлбөрийн дүн нь үлдэгдэл төлбөрийн дүнд тооцсон хүүгийн зардлын улмаас өсөж, төлсөн түрээсийн төлбөрийн дүнгээр буурна. Ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн үлдсэн хугацааны турш эсвэл хөрөнгийн ашиглалтын хугацаа нь түрээсийн хугацаанаас богино байх ховор тохиолдолд хөрөнгийн эдийн засгийн ашиглалтын үлдсэн хугацааны турш шулуун шугамын аргаар хорогдуулна.

Компани аливаа түрээсийн хугацааны тооцоололд өөрчлөлт оруулсан бол (жишээ нь, сунгах эсвэл цуцлах сонголтыг түрээслэгч хэрэгжүүлэх магадлалыг дахин үнэлсэн гэх мэт шалтгаанаар) шинэчлэгдсэн хугацааны турш хийх төлбөрийг илтгэхийн тулд түрээсийн өр төлбөрийн дансны үнэд тохируулга хийх бөгөөд үүнийг түрээсийн эхлэлд мөрдөж байсантай ижил дискаунтын хувь ашиглан дискаунтчилна. Хувь хэмжээ эсвэл индексээс хамааралтай ирээдүйн түрээсийн төлбөрийн хувьсах элементүүдийг шинэчилсэн бол түрээсийн өр төлбөрийн дансны үнийг ч мөн шинэчилнэ. Аль ч тохиолдолд ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнэд зохих тохируулгыг хийх бөгөөд шинэчилсэн дансны үнийг түрээсийн үлдсэн (шинэчилсэн) хугацааны турш хорогдуулна.

Компани нь түрээслүүлэгчтэй түрээсийн гэрээний нөхцөлийг дахин хэлэлцэж байх үед гэрээнд орох өөрчлөлтийн шинж чанараас хамаарч нягтлан бодох бүртгэл нь ялгаатай байна:

- хэрэв дахин хэлцлийн үр дүнд нэмэлт хөрөнгө ашиглах эрхийн бие даасан үнэтэй дүйцэх нэг эсвэл түүнээс олон нэмэлт хөрөнгийг түрээслэхэд хүргэж байвал дээрх бодлогын дагуу уг өөрчлөлтийг түрээс гэж бүртгэнэ;
- дахин хэлцэл нь түрээсийн хамрах хүрээг өсгөж буй бусад бүх тохиолдолд (түрээсийн хугацааг сунгасан, эсвэл нэг эсвэл түүнээс олон нэмэлт хөрөнгийг түрээслэх болсон эсэхээс үл хамааран) өөрчлөлтийн өдрөөр хамаарах дискаунтын хувийг ашиглан түрээсийн өр төлбөрийг дахин хэмжих бөгөөд ашиглах эрхтэй хөрөнгийг ижил дүнгээр залруулна;

Хэрэв дахин хэлцлийн үр дүнд түрээсийн хамрах хүрээ буурахад хүрсэн тохиолдолд түрээсийн бүрэн эсвэл зарим хэсгийг цуцалсан хэмжээг илтгэхийн тулд түрээсийн өр төлбөр болон ашиглах эрхтэй хөрөнгийн аль алины дансны үнийг ижил хэмжээгээр бууруулж, аливаа үүссэн зөрүүг ашиг, алдагдалд тусгана. Үүний дараа дансны үнэ нь дахин хэлэлцсэн хугацааны турш дахин хэлэлцсэн төлбөрийн дүнг илтгэж байгаа гэдгийг бататгахын тулд түрээсийн өр төлбөрт нэмж тохируулга хийх бөгөөд үүний тулд өөрчлөгдсөн түрээсийн төлбөрийг өөрчлөлтийн өдрөөр хамаарах хувь хэмжээг ашиглан дискаунтчилна. Ашиглах эрхтэй хөрөнгийг ижил дүнгээр тохируулна.

## 34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (*үргэлжлэл*)

***Худалдан авсан биет бус хөрөнгө***

Гаднаас худалдан авсан биет бус хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч дараа үеудэд түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга ба үнэ цэний бууралтыг хассан дүнгээр бүртгэж эдийн засгийн ашиглалтын хугацаанд нь шулуун шугамын аргаар хорогдуулна. Ашиглалтын хугацаа тодорхойгүй биет бус хөрөнгөд хорогдол тооцохгүй бөгөөд тайлант үе бүрийн эцэст аливаа үнэ цэний бууралт байгаа эсэхийг хянаж үзнэ.

Биет бус хөрөнгийг худалдан авсан аж ахуйн нэгжээс нь салгаж болохуйц эсвэл бусад гэрээгээр хүлээсэн үүсгэж байгаа тохиолдолд бизнесийн нэгдлийн үед хүлээн зөвшөөрнө. Ийм төрлийн биет бус хөрөнгийн үнийн дүнг тохирох үнэлгээний арга техникийг ашиглан тооцоолно.

***Өмч, барилга, тоног төхөөрөмж***

*Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны өртөгт худалдан авсан үнэ, тухайн хөрөнгийг компанийн зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгоход шаардагдах худалдан авалттай холбоотой зардлууд багтах бөгөөд үүнд мөн холбогдох зээлийн зардлыг оруулдаг.

*Хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилт*
Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх хүлэн зөвшөөрсний дараа үеэс анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр нь хэмжинэ. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлс нь ашиглалтын ялгаатай хугацаатай томоохон бүрэлдэхүүнээс бүрдэж буй тохиолдолд бүрэлдэхүүн хэсгүүдийг барилга, тоног төхөөрөмжийн зүйл болгон бүртгэдэг.

*Элэгдэл*
Газарт элэгдэл тооцдоггүй. Дуусаагүй барилгыг бүрэн барьж, ашиглахад бэлэн болох хүртэл элэгдүүлдэггүй. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн бусад бүх зүйлсэд элэгдэл тооцох бөгөөд ингэснээрээ тэдний дансны үнэ цэнийг таамагласан ашиглалтын хугацааны туршид данснаас хасах юм. Тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд авчирсан буюу ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлэх өртгөөс шулуун шугамын аргаар элэгдэл тооцох бөгөөд элэгдлийг тайлант жилийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Элэгдүүлэх өртөг нь тухайн хөрөнгийн анхны өртгөөс ашиглалтын хугацааны эцэст буцаан борлуулах боломжит өртгийг хассан дүн байна. Элэгдүүлэлтийн арга, ашиглах хугацаа, үлдэх өртгийг тайлагнах үе бүрд дахин тооцож үзнэ.

Өмч, барилга, тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна:

| Өмч, барилга, тоног төхөөрөмж | Ашиглалтын хугацаа |
|---|---|
| Барилга, байгууламж | 40 жил |
| Машин, тоног төхөөрөмж | 10 жил |
| Тавилга, эд хогшил | 10 жил |
| Компьютер дагалдах хэрэгсэл | 3 жил |
| Тээврийн хэрэгсэл | 10 жил |

## 34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

***Өмч, барилга, тоног төхөөрөмж** (үргэлжлэл)*

*Данснаас хасалт*

Өмч, барилга, тоног төхөөрөмж ба түүний томоохон хэсгүүдийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүртэхгүй болсон үед данснаас хасна. Үүнтэй холбоотойгоор үүссэн аливаа олз, гарзыг (хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого ба дансны үнэ хоёрын зөрүүгээр тооцно) тухайн тайлант жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Өмч, барилга, тоног төхөөрөмжийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдах буй ирээдүйн эдийн засгийн үр ашгийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрд хянаж үздэг.

***Урьдчилж төлсөн төлбөр***

Өртгөөс үнэ цэний бууралтын санг хассан дүнгээр урьдчилж төлсөн төлбөрийг бүртгэнэ. Хэрэв урьдчилгааг нь төлсөн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг нэг жилийн дараа хүлээн авахаар бол эсвэл урьдчилгаа нь төлөгдсөн хөрөнгө өөрөө анхны хүлээн зөвшөөрөлтөөрөө эргэлтийн бус хөрөнгөд ангилагдахаар бол урьдчилгааг эргэлтийн бус хөрөнгө гэж бүртгэнэ. Компани тухайн хөрөнгийг хянан зарцуулахаас гадна тухайн хөрөнгөтэйгөөр холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг хүртэх магадлалтай болмогц хөрөнгө худалдан авахаар төлсөн урьдчилгаа төлбөрийг хөрөнгийн дансны үнэ рүү шилжүүлнэ. Бусад урьдчилгаа төлбөрийг тухайн урьдчилж төлсөн төлбөрт хамаарах бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг хүлээн авсан үедээ ашиг, алдагдал руу хааж бичнэ. Хэрэв урьдчилгаа хийгдсэн хөрөнгө, бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг хүлээн авахааргүй нь ил болбол тухайн урьдчилгааг бүртгэлийн үнээр нь данснаас хасаж түүнтэй холбоотой үнэ цэний бууралтыг тухайн тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

***Бараа материал***

Бараа материалыг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч дараа үеүдэд өртөг ба цэвэр боломжит үнэ цэний аль багаар нь хэмжинэ. Бараа материалын өртөгт худалдан авалттай холбоотой бүх зардал, хувиргалтын зардал болон бараа материалыг өнөөгийн байршил ба нөхцөлд авч ирэхтэй холбоотой гарсан бусад бүх зардал багтана.

Цэвэр боломжит үнэ цэн нь тогтоогдсон борлуулах үнээс зарж борлуулахтай холбоотой зардлуудыг хассан дүнгээр тодорхойлогдоно. Хуучирсан, илүүдэл нөөцтэй, болон удаан гүйлгээтэй бараа материалуудыг олж тогтоож, цэвэр боломжит үнэ хүртэл нь бууруулж бүртгэдэг.

Хэвийн харилцан сольж болохуйц зүйлсийн өртгийг тодорхойлоход жигнэсэн дундаж өртгийг хэрэглэдэг.

***Засгийн газрын буцалтгүй тусламж***

Компани засгийн газрын буцалтгүй тусламж олгоход тавигдсан шалгуурыг хангаж чадах эсэхийг үнэлж үзсэний үндсэн дээр хэрэгжих өндөр магадлалтай үед түүнийг холбогдох зардлаас тусад нь нийт дүнгээр нь орлогоор хүлээн зөвшөөрдөг.

## 34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (*үргэлжлэл*)

***Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба өр төлбөр***

Дараах тохиолдолд эргэлтийн бус хөрөнгө болон борлуулах бүлэг хөрөнгийг борлуулах зорилготой гэж ангилна:

- Шууд борлуулахад бэлэн
- Удирдлага бүтээгдэхүүнийг борлуулахаар шийдсэн
- Төлөвлөгөөнд ямар нэгэн томоохон өөрчлөлт орох эсвэл төлөвлөгөөг цуцлах магадлал бага
- Худалдан авагчдыг тогтоох идэвхтэй хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн
- Хөрөнгө эсвэл борлуулах бүлэг хөрөнгийг бодит үнэ цэнтэй нь харьцуулахад тогтоосон үнэ нь ул үндэслэлтэй, ба
- Ангилал хийсэн өдрөөс хойш 12 сарын дотор борлуулалт хийгдэнэ гэж үзэж байгаа.

Борлуулах зориулалттай гэж ангилсан эргэлтийн бус хөрөнгө болон борлуулах бүлэг хөрөнгийг дараах зүйлсийн аль багаар нь хэмжинэ:

- Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу борлуулахад бэлэн гэж ангилахын өмнөх дансны үнэ; ба
- Борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэн.

Борлуулах зорилготой гэж ангилсны дараа эргэлтийн бус хөрөнгийг (борлуулах бүлэг хөрөнгө дэх хөрөнгө багтана) элэгдүүлэхгүй.

Тайлант жилд борлуулсан үйл ажиллагааны үр дүнг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд борлуулалтын өдөр тусгана.

***Биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн***

Компани нь сүүний чиглэлийн үхрийг биологийн хөрөнгөөр бүртгэж тайлагнадаг. 0-2 настай биологийн хөрөнгийг өсвөр гэж нэрлэх бөгөөд эргэлтийн биологийн хөрөнгөөр ангилан бүртгэдэг. 2-оос дээш настай тугаллаж сааль өгөх үнээнүүдээ үндсэн сүргээр бүртгэж эргэлтийн бус биологийн хөрөнгөөр ангилдаг.

Төл хүлээн авахад болон тайлант жил бүрийн эцэст биологийн хөрөнгийг борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжиж тайлагнадаг. Тайлант хугацаанд гарсан биологийн хөрөнгийн асаргаа, маллагаатай холбоотой түүхий эд материал, шууд болон шууд бус хөдөлмөр болон бусад нэмэгдэл зардлуудыг хуримтлуулан бүртгэж биологийн хөрөнгийн дансны үнийг капиталжуулдаг. Тайлант үе бүрийн эцэс дэх хөрөнгийн дансны үнэ болон бодит үнэ цэний зөрүүг Биологийн хөрөнгийн бодит үнэ цэний олз, гарзаар хүлээн зөвшөөрч ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд толилуулдаг.

Биологийн хөрөнгөөс хүлээн авсан бүтээгдэхүүнийг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гэж нэрлэх бөгөөд санхүүгийн байдлын тайланд Бараа материалаар ангилж толилуулдаг. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хүлээн авах үед буюу анхны хэмжилтээр болон дараа үеүдэд борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмждэг. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн бий болгохтой холбоотой гарсан зардлыг хуримтлуулан бүртгэж сүү хүлээн авах үед уг хуримтлагдсан өртөг болон бодит үнэ цэний зөрүүгээр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бодит үнэ цэний олз, гарзыг хүлээн зөвшөөрч ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг.

## 34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (*үргэлжлэл*)

***Санхүүгийн орлого ба зардал***

Санхүүгийн орлого, зардалд хүүгийн орлого/зардал, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз/гарз, санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэний олз/гарз хамаарна. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай капиталжуулагдсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

***Хойшлогдсон татвар***

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагддаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татвар хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг юм.

санхүүгийн байдлын тайланд тусгасан хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ нь татварын сууриас зөрүүтэй байгаа тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрдөг. Харин дараах зүйлсээс үүссэн зөрүүг хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр гэж үзэхгүй:

- Гүүдвилийн анхны хүлээн зөвшөөрөлт
- Тухайн ажил гүйлгээ гарсан үедээ нягтлан бодох бүртгэлийн эсвэл татварын ашгийн алинд нь ч нөлөөлдөггүй, бизнесийн нэгдлийн бус ажил гүйлгээний хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлт, ба
- Гарсан зөрүүнд буцаалт хийх хугацааг компани хянах чадвартай охин компани болон хамтарсан хэлэлцээрт оруулсан хөрөнгө оруулалт ба тухайн зөрүүг ойрын ирээдүйд буцаахгүй байх магадлалтай байх.

Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрд хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог.

Хөрөнгө эсвэл өр төлбөрийн татварын суурь, тодорхой ажил гүйлгээний татвар ногдох байдал, эсвэл татвартай холбоотой бусад төсөөлөлтэй холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдолд Компани нь:

- Тодорхой бус татварын байр суурийг тусад нь эсвэл багцлан авч үзэх эсэх (шийдвэрлэлтийг нь хамгийн сайн таамаглаж чадах аргад үндэслэн);
- Тодорхой бус татварын байр суурийг татварын алба хүлээн зөвшөөрөх магадлалтын эсэхийг тодорхойлох: ба
- Тодорхой бус татварын байр суурийг хүлээн зөвшөөрөх магадлалгүй бол тодорхой бус байдлын шийдвэрлэлтийг хамгийн сайн таамаглах аргаас хамаарч хамгийн боломжит үнийн дүн эсвэл таамагласан үнэ цэний аргад үндэслэн тодорхой бус татварын байр суурийг хэмжинэ. Энэхүү хэмжилтийг хийхийн тулд татварын алба тус бүр өөрсдийн шалгах эрхтэй бүхий л үнийн дүнг шалгах бөгөөд эдгээр шалгалтыг хийхдээ холбогдох бүх мэдээллийн талаар бүрэн мэдлэгтэй байна эгсэн төсөөлөлд суурилахыг шаарддаг.

## 34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

***Хойшлогдсон татвар** (үргэлжлэл)*

Компани нь тайлант жилийн татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэрлэх хуульд заасан эрхтэй бөгөөд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь нэг ижил татварын эрх бүхий байгууллагад ногдуулсан татвартай дараах нөхцөлийн аль нэг байдлаар холбоотой байгаа бол хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хооронд нь цэвэрлэнэ.

- Татвар ногдуулах ижил байгууллага, эсвэл
- Татвар ногдуулах ялгаатай байгууллагаас цэвэр сууриар тайлант үеийн өр төлбөрийг ба хөрөнгийг барагдуулах эсвэл ирээдүйн тайлант үе бүрд барагдуулахаар буюу нөхөхөөр төлөвлөсөн хойшлогдсон татварын өр төлбөр буюу хөрөнгийн нөлөө бүхий дүнгээр хөрөнгийг хүлээн авсан ба өр төлбөрийг нэгэн зэрэг барагдуулахаар төлөвлөсөн.

***Нэгж хувьцаанд ногдох ашиг***

Нэгж хувьцаанд ногдох ашиг, алдагдал нь компанийн тайлант жилийн турш эргэлтэд байсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хуваарилагдсан цэвэр ашиг, алдагдлаар тооцоологддог. Энэ нь энгийн хувьцаа нэг бүрд ногдох тайлант жилийн ашиг, алдагдлын дүнг илэрхийлнэ. Компани аливаа хорогдуулагч хэрэглүүр эзэмшдэг бол нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг, алдагдлын тооцоог мөн хийж тайлагнана.

***Ажилчдын тэтгэмж***

*Түр хугацааны ажилчдын тэтгэмж*

Богино хугацаат ажилчдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй сууриар хэмжигддэг бөгөөд ажилчдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг. Хэрэв ажилчдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн компани хуулийн дагуу бонус өгөх хариуцлага хүлээх болон бонусын дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат бонусын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

*Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал*

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

***Болзошгүй үйл явдлууд***

Санхүүгийн тайланд болзошгүй өр төлбөрүүдийг хүлээн зөвшөөрдөггүй. Эдийн засгийн үр өгөөж агуулсан эх үүсвэр гадагшлах магадлал бага биш бол эдгээр өр төлбөрийн талаар санхүүгийн тайланд тодруулга хийнэ. Санхүүгийн тайланд болзошгүй хөрөнгүүдийг хүлээн зөвшөөрөхгүй боловч эдийн засгийн өгөөж орж ирэх нь магадлалтай болсон үед санхүүгийн тайланд толилуулна.

## 34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (*үргэлжлэл*)

***Холбоотой талууд***

Хэрвээ тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь тухайн компанийн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн компани өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог. Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад аж ахуйн нэгжүүд байж болно

а) Аливаа хувь хүн эсвэл түүний ойр дотнын гэр бүлийн гишүүнийг дараах тохиолдлуудад компанийн хувьд холбоотой тал гэж үзнэ. Хувь хүн нь:
- (i) Компанийг хянадаг эсвэл хамтын хяналттай бол;
- (ii) Компанид мэдэгдэхүйц нөлөөтэй бол; эсвэл
- (iii) Компани эсвэл түүний толгой компанийн гол удирдлагын багийн гишүүний нэг бол.

Компанийг дараах тохиолдлуудад нөгөө компанийн холбоотой тал гэж үзнэ:
- (i) Нэг групп компанийн бүрэлдэхүүн компаниуд хоорондоо холбоотой талууд байна;
- (ii) Компани нь нөгөө компанийнхаа хараат компани эсвэл хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол (эсвэл компани нь нөгөө компанийн харьяалагддаг группийн өөр нэг гишүүн компанийн хараат компани эсвэл хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол);
- (iii) Хоёр компани хоёулаа нэг ижил гуравдагч талын хамтарсан хөрөнгө оруулалттай компаниуд бол;
- (iv) Компани нь гуравдагч талын хамтарсан хөрөнгө оруулалттай компани ба нөгөө компани нь уг гуравдагч талын хараат компани бол;
- (v) Компани нь нөгөө компанийн эсвэл түүнтэй холбоотой компанийн ажиллагсдын ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөрийн үйл ажиллагааг эрхэлдэг бол;
- (vi) (а)-д тодорхойлогдсон хувь хүн нөгөө компанид хяналт эсвэл хамтын хяналттай бол; эсвэл
- (vii) (а)(i)-д тодорхойлогдсон хувь хүн нөгөө компанид мэдэгдэхүйц нөлөөтэй, эсвэл нөгөө компани эсвэл түүний толгой компанийн гол албан тушаалтны нэг бол.

Компанитай хийх хэлцэлд өөрөө болон уг хувь хүнээр дамжуулан нөлөө үзүүлэх магадлалтай гэр бүлийн гишүүдийг ойр дотнын гэр бүлийн гишүүнд тооцно.
Холбоотой талуудын хооронд ажил гүйлгээ гарсан эсэхээс үл хамааран тэдгээрийн хоорондын харилцааг тодруулах ёстой.
Холбоотой талуудын ажил гүйлгээний тодруулгад дараах зүйлсийг тодруулна.
- (а) Худалдан авалт
- (б) Борлуулалт
- (в) Түрээс
- (г) Зээл
- (д) Баталгаа, барьцааны нөхцөлүүд
- (е) Хэрэв ирээдүйд тодорхой нэг үйл явдал хэрэгжих эсвэл хэрэгжээгүй үед ямар нэг үүрэг хүлээх амлалт
- (ж) Аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс эсвэл холбоотой талын нэрийн өмнөөс аж ахуйн нэгж өр төлбөрийг барагдуулах

Компанийн санхүүгийн тайланд холбоотой талуудын ажил гүйлгээний нөлөөллийг тусад нь харуулах шаардлагатайгаас бусад тохиолдолд ижил үзүүлэлтүүдийг нийтэд нь тодруулж болно.

## 35. Тайлангийн орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд тэдгээрийн хооронд ялгаа, зөрчилдөх зүйл гарвал Монгол хэл дээрх хувийг баримтална.